

## 4.6. УРЛАГ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ

### 4.6.1. Урлаг, дизайн, технологийн судлагдахууны интеграц

#### Удиртгал

Нийгэм, эдийн засаг, техник технологи өндөр хөгжиж буй өнөө үед хөгжлийг дагасан сөрөг үзэгдлүүд, түүнтэй холбоотой яаралтай шийдвэрлэх олон асуудлууд дэлхийн улс орнуудад тулгараад байгаа билээ.

Тогтвортой хөгжил ба ТХБ-ын холбоо хамаарлыг 2016 онд хийгдсэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа”-ны тайланд “Тогтвортой хөгжил бол хүн бүрд хамаатай, газар бүр хэрэгжих учиртай нийгэм бүхэлдээ өөрчлөн шинэчлэгдэх үйл явц харин Тогтвортой хөгжлийн боловсрол бол байнгын шинэчлэл бүхий энэхүү үйл явцыг хэрэгжүүлэх арга зам” хэмээн тодорхойлсон байна. Энэ нь боловсролоор дамжин тогтвортой хөгжилд хүрэх ойлголттой нийцэж байгаа юм.

Дэлхий нийтээр боловсролыг өөрчлөлтийн хөдөлгөгч хүч, тогтвортой хөгжлийн боловсрол нь тогтвортой хөгжлийг хангах хамгийн чухал суурь гэж<sup>132</sup> үзэж байгаа энэ үед суралцагчдыг ухаалаг, хариуцлагатай хэрэглээнд суралцахад нь урлаг, дизайн технологийн хичээл тодорхой хувь нэмэр оруулахаар байна.

ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөний дагуу хөгжмийн хичээлийг I-IX ангид, дүрслэх урлагийн хичээлийг I-VIII ангид, дизайн технологийн хичээлийг I-XII ангид тус тус судалж байна. Мөн хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологийн хичээл бага боловсролд зорилго, хүрэх үр дүнгээр нэг, агуулга, аргагүй, үнэлэх шалгуур нь тус тусдаа, суурь боловсролд хөгжим, дүрслэх урлагийн хичээл зорилго, зорилт, хүрэх үр дүн нэг бол, дизайн технологийн хичээл нь бие даасан байдлаар судлахаар сургалтын хөтөлбөрт тусгагдсан байдаг. Иймд бид энэхүү судлах агуулгын хүрээнд шинжилгээг хийсэн болно.

Урлагийн бага болон суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго нь “Сурагчийг хүрээлэн буй орчин, юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, өөрийн авьяас, гоо сайхны мэдрэмжээ бүтээлчээр илэрхийлж, хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, урлаг соёлыг эрхэмлэдэг иргэн болж төлөвших”-д дэмжлэг үзүүлэх бол дизайн технологийн суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго нь “сурагчийг дизайн, техник, технологийн үйл явцыг танин мэдэх арга барилаа хөгжүүлж, байгаль, үндэсний соёлоо дээдэлсэн, бүтээлч сэтгэлгээтэй, дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх чадвар эзэмшсэн иргэн болж төлөвших”-д<sup>133</sup> дэмжлэг үзүүлэхээр тодорхойлсон байдаг.

Энэхүү сургалтын хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлснээр ТХ-ийн зорилго, зорилт, тогтвортой байдлын цогц чадамжийг төлөвшүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой байна. Тухайлбал:

- Уур амьсгалын өөрчлөлт түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг яаралтай авах, экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилттэй

132 НҮБ-ын ЕА эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр

133 БСШУЯ. (2015). Суурь боловсролын цөм хөтөлбөр. УБ.

тэмцэх, хариуцлагатай тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих зорилгуудтай урын сан, үйлээр дамжин хамаарах боломжтой юм.

- Мөн ТХ-ийн эдгээр агуулгыг дизайн технологийн хичээлд дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх, ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж хамтран ажилладаг, уламжлалт болон орчин үеийнээр агуулгыг дизайн технологийн хичээлд дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх, ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмэр оруулна. Харин хөгжмийн хичээлийн хувьд дээрх агуулгыг дуулах, хөгжимдөх, зохион найруулах үйлд тулгуурлан, урлагийн бүтээлээр дамжуулан мэдэрч ойлгох, сонирхон судлах, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, хамтран ажиллах замаар бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцахад чиглэгдсэн байна.

#### Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал

Бүх шатны сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, багшлах арга зүйд тогтвортой хөгжлийн үзэл санааг тусган хэрэгжүүлэх, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд сургалтын байгууллагууд хувь нэмэр оруулах, харилцан туршлага солилцож, хамтран ажиллах нь тогтвортой хөгжлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх бодит үйл хэрэг болох гол арга зам байна<sup>134</sup> гэж тусгажээ.

Урлаг, дизайн технологийн хичээлүүдийн цөм хөтөлбөр дэх ТХБ-ын агуулгын интеграцчилганд байдлыг төслийн ерөнхий дизайны дагуу матриц 1-д тодорхойлоход нийт 37 суралцахуйн зорилт тодорхойлогдсоныг судлагдахуунаар, боловсролын түвшнээр, ТХЗ-ын суралцахуйн зорилтоор ялгаж харууллаа. (Хүснэгт 4.6.1) Хичээл тус бүрээр тодорхойлогдсон суралцахуйн зорилт тус бүрийг ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй холбогдох байдлыг матриц 1-ээс, арга зүйн интеграцчилал буюу ТХЗ-ын сургалтын аргын төрөл, ТБ-ын цогц чадамжид оруулах хувь нэмрийг хэрхэн тодорхойлсныг матриц 2-оос үзнэ үү.

Урлаг, дизайн технологийн хичээлд эдгээрийг хэрхэн интеграцчилах арга замыг тодорхойлохдоо бага боловсролын хөгжим, дүрслэх урлаг-технологи, суурь боловсролын хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологийн сургалтын хөтөлбөрийн агуулга болон ТХБ-ын суралцахуйн зорилт, сэдэв нэг бүрийг харьцуулан авч үзсэн болно. Тухайлбал

- Бага боловсролын дүрслэх урлаг-технологийн сургалтын хөтөлбөрийн “3.01.9.<sup>135</sup> Байгалийн материалыг баримлын шавраар холбох аргаар биет тоглоом хийх” агуулга нь ТХ-ийн “Газар дээрх амьдрал”-ын талаарх 15 дугаар зорилгын “Суралцагч орон нутгийн байгаль орчинтой харилцаж, дэлхий дээрх хүний бус аж амьдралыг ойлгож чаддаг болох” суралцахуйн зорилттой холбогдож байна.
- Харин суурь боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрийн “9.03.1.<sup>136</sup> Хөгжмийн бүтээлийг сонирхон судлах замаар орчин үеийн хөгжмийн зохиолчдын арга барил, бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх,

134 БСШУ-ны сайдын 2016.11.13, хавсралт.

135 Хавсралт: Дүрслэх, технологийн матриц 1

136 Хавсралт: Хөгжмийн матриц 1

сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваалцана. С.Сансаргэрэлтэх – “Эх дэлхийгээ аварцаага” зохиолын агуулга нь “Уур амьсгалын төлөөх үйл хэрэг”-ийн талаарх 13 дугаар зорилгод тодорхойлогдсон “Суралцагч нь нийтээрээ хүлээн зөвшөөрсөн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх стратегийг боловсруулж, бусадтай хамтран ажиллаж чаддаг болох” суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх боломжтой байна.

Тайлбар: Сургалтын хөтөлбөрийн агуулгыг дараах байдлаар кодлон тэмдэглэсэн болно. Тухайлбал: 3.01.9 нь бага боловсролын дүрслэх урлаг-технологийн сургалтын хөтөлбөрийн “анги тус бүрийн агуулга”-ын 3 дугаар ангийн “Урлагийн хэл” хам сэдвийн “Зохиомжийн хэрэгсэл тэдгээрийг ашиглан зурах дүрслэх зохион бүтээх арга барил эзэмших” бүлэг буюу 01, агуулгын 9 дэх суралцахуйн зорилт “Байгалийн материалыг баримлын шавраар холбох аргаар биет тоглоом хийх” гэж ойлгож уншина. (БСШУЯ., Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр., 2015., 58-59)

Харин “9, 03.1” нь суурь боловсролын хөгжмийн сургалтын хөтөлбөрийн “анги тус бүрийн агуулга”-ын 9 дүгээр ангийн 03 буюу “Хөгжимдөх” хэсгийн 1. Хөгжмийн бүтээлийг сонирхон судлах замаар орчин үеийн хөгжмийн зохиолчдын арга барил, бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, задлан шинжлэл хийх, сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваалцана” агуулгыг кодолсон болно.

*Шинжилгээг хийхдээ дараах шаардлагыг баримталсан болно. Үүнд:*

- ТХ-ийн зорилго, сэдэв болон суралцахуйн зорилтын холбоо хамаарал, тэдгээрийн ерөнхий зүй тогтол буюу түлхүүр үгийн сонголтыг харгалзах,
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэглэгдэхүүн буюу урын сангийн жагсаалтыг гаргах,
- Урлаг, дүрслэх урлаг-технологийн хичээлийн агуулга алдагдахгүй хэрэгжих боломжтой байх,
- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг ТХБ-той интеграцчилахад багш санаа авахаар тодорхой байх

Агуулгыг сонгохдоо ТХ-ийн зорилгын суралцахуйн зорилт болон тогтвортой байдлын цогц чадамжид баримжаалсан бөгөөд багш эдгээрээс санаа авч өдөр тутмын хичээлээ боловсронгуй болгож, хэрэглээ талаас нь суралцагчдад ойлгуулахад дөхөм болох байдлыг түлхүү харгалзсан болно.

Урлаг, дүрслэх урлаг хичээлийн агуулга нь ТХЗ-ын суралцахуйн зорилт, агуулга, зорилготой шууд бус давхцаж байна. Тухайлбал: сургалтын хөтөлбөрийн 2-р ангийн “Аялгууны шинж төрхийг ойлгох, сонсож таних, тодорхойлох, ялгах, тайлбарлах” суралцахуйн зорилт нь ТХ-ийн 11-р зорилготой шууд холбогдохгүй хэдий ч “Хувдай ишигний паян” зохиолоор дамжуулан суурин амьдралын хэв маягийн түүхэн шалтгааныг ойлгож, соёлын өв уламжлалыг хүндэтгэдэг, ойлгодог болоход дэмжлэг үзүүлэхээр байна.

Харин Дизайн технологийн хичээлийн агуулга нь ТХБ-ын зарим суралцахуйн зорилт, агуулга, зорилготой шууд холбогдож байна. Тухайлбал: 6-р ангийн “Техник” агуулгын хүрээнд “хэрэглээнээс гарсан боловч дахин ашиглах боломжтой материалуудыг сонгон ашиглах, хэрэгцээт эд зүйлс хийх, бүтээх хандлагатай болно” суралцахуйн зорилт нь ТХ-ийн 12-р зорилготой шууд холбогдож байна.

*Хүснэгт 4.6.1. Урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт*


ТХЗорилго	Хөгжим		Дүрслэх урлаг		Дизайн технологи	Нийт
	бага	суурь	бага	суурь	суурь	
ТХ301. Ядууралгүй байх						0
ТХ302. Өлсгөлөнгүй тэглэх					1	1
ТХ303. Эрүүл мэнд ба сайн сайхан байдал	2	1	1		1	5
ТХ304. Чанартай боловсрол	1	1		1	3	6
ТХ305. Жендерийн тэгш байдал						0
ТХ306. Цэвэр ус ба ариун цэвэр	1	1				2
ТХ307. Боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүч						0
ТХ308. Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт			1		2	3
ТХ309. Үйлдвэрлэл, инноваци, дэд бүтэц					1	1
ТХ310. Тэгш бус байдлыг багасгах						0
ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид	1		1	1		3
ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл			2	1	3	6
ТХ313. Уур амьсгалын төлөөх үйл хэрэг	1	1				2
ТХ314. Усан доторх амьдрал						0
ТХ315. Газар дээрх амьдрал		1	1	3	1	6
ТХ316. Энх тайван, шударга ёс, хүчирхэг институциуд	1					1
ТХ317. ТХЗ-ын төлөөх түншлэл					1	1
Нийт	7	5	6	6	13	

ТХ-ийн 17 зорилгоос ТХ303, ТХ304, ТХ312, ТХ315-д хамаарах суралцахуйн зорилт түлхүү байна. Энэ нь газар дэлхийн гоо сайхан болон мөхөл сүйрлийг хөгжим, уран зургаар илүү тод томруун илэрхийлдэгтэй холбоотой юм.

ТХ303. Эрүүл мэнд, сайн сайхан байдалд харгалзаж байгаа суралцахуйн зорилт нь хөгжмийн суралцахуйн зорилт байгаа бол ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлд харгалзах суралцахуйн зорилт дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлийнх байна. Харин хамгийн нийтлэг интеграцчилал нь газар дээрх амьдралд хамаарч байна.

ТХ304. Чанартай боловсролын зорилгод хамаарах ТХ-ийн сэдэв, суралцахуйн зорилт тус гурван хичээлийн хөтөлбөрт тодорхой хэмжээнд орсон байна.

Зураг 4.6.1. Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт (ТХЗ-оор, хувиар)




Урлаг, дизайн технологийн хичээлүүдийн ТХЗ-той интеграцчилагдсан байдлаас харахад бага боловсролын түвшинд НСХ-ийн суралцахуйн зорилт их байгаа нь Урлаг/хөгжим, дүрслэх урлаг, технологи/-ийн агуулгад суралцагч гоо сайхныг мэдрэх, түүнийгээ бүтээлчээр илэрхийлэх аргад суралцахаар тусгагдсантай холбогдож байна. Эдгээрийг хичээлийн арга зүйн шийдэл, урын сангийн сонголтоор сурагчдад хандлага, зан үйл төлөвших, ТХ-ийн асуудалд хувь хүний ёс зүйгээр ханддаг чадвар эзэмшүүлэхэд чиглүүлж өгнө гэж үзэж байна. Тухайлбал:

**Танин мэдэхүйн:** Даяаршил, хөгжлийн асуудалтай холбогдох мэдээлэл цуглуулах, боловсруулах, даяаршсан дэлхий дэх нийгэм-соёл, байгалийн олон янз байдлыг танин мэдэх, даяаршил, хөгжлийн үйл явцад ТХ-ийн зарчмын үүднээс дүн шинжилгээ хийж, танин мэдэхүйгээ хөгжүүлнэ. Ингэхдээ сурагчид урлагийн бүтээлээр дамжуулж ойлгох болно.

**Нийгэмшил сэтгэл хөдлөл:** Хувь хүнээс эхлүүлэн даяаршил хүртэлх нийгмийн харилцааны янз бүрийн түвшнийг мэдэх, хөгжлийн үйл явцад тэдгээрийн үүргийг ойлгох, нийгмийн харилцааны түвшин хоорондын ялгаатай байдал, урлаг, соёлын олон талт хүчин зүйлсийг ойлгох, хүндэтгэхэд чиглэгдэнэ.

**Зан үйлийн:** Хүн төрөлхтөн, хүрээлэн буй орчны өмнө хүлээх хувь хүний хариуцлагаа ухамсарлах, харилцах, хамтран ажиллахад нийгэм-соёлтой холбогдох бэрхшээлийг даван туулах, өөрчлөлтөд нийгмийн зүгээс хийх үйлийн талаар тодруулах, ялангуяа тодорхой бус нөхцөлд санаачилгатай байх, асуудлын бэрхшээлтэй талыг бууруулах, тэвчээртэй хандах зэргээр хувь хүний чадвараа хөгжүүлэх, ТХ-ийн зорилгуудыг амьдрал, сургууль, мэргэжил, ажилдаа хэрэгжүүлэх, түүнд тулгуурлан шийдвэр гаргах, үйл хийх, нийгэм, улс төрийн асуудалд идэвхтэй оролцох зэргээр хувь нэмрээ оруулна.

Зураг 4.6.2. ТХЗ-д хамаарах Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт (хувиар)



а. ТХБ-ын суралцахуйн зорилтын айгаар

б. Боловсролын түвшнээр

Сургалтын цөм хөтөлбөрт дүрслэх урлаг, хөгжмийн хичээл нь зорилго, сурах арга барил, хүрэх үр дүнгээр нэгдсэн тус тусдаа бие даасан агуулгыг судална гэж дээр дурдсан бөгөөд аливаа юмс үзэгдэл, урлагийн бүтээлийг мэдэрч ойлгох, сонирхон судлах, бүтээх, хөгжүүлэх, илэрхийлэх, үнэлэх арга барил, гүйцэтгэлийн чадвараа хөгжүүлэх, бүтээлчээр сэтгэн өөрийн санааг илэрхийлэх аргад суралцах, өдөр тутмын амьдралд хэрэглээ болгоход чиглэсэн чадвараар илэрхийлэгдэнэ гэж тодорхойлсон нь ТХ-ийн НСХ-ийн зорилт нэмэгдэж байгаатай илүү хамаарч байгаа харагдаж байна.

Урлаг, дизайн технологийн хичээлийн суралцахуйн зорилт буюу агуулга нь ТХ, ТХБ-той шууд холбогдохгүй хэдий ч тэдгээрт ашиглаж байгаа сургалтын хэрэглэгдэхүүн болох уран бүтээлээр дамжуулан ТХ, ТХБ-ын мэдлэг, ойлголтыг бататгахад дэмжлэг үзүүлэх нь харагдаж байна.

*Суралцахуйн зорилт, арга зүй, цогц чадамжийн интеграцын тодорхойлогдсон байдал*

Урлаг, дизайн технологийн цөм хөтөлбөрийн тухайн суралцахуйн зорилтыг ТХБ-той интеграцчилсан байдлаар хэрэгжүүлэхэд тохиромжтой аргыг сонгож, түүний үндэслэлийг хэрхэн тодорхойлсныг матриц 2-оос дэлгэрэнгүйгээр үзэж болох бөгөөд ТХЗ-ын төлөөх боловсролыг хэрэгжүүлэх аргуудаас бага боловсролд бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд түлхүү ашиглагдахаар харагдаж байна. (Хүснэгт 4.6.3) Энэ нь бага насны хүүхэд аливаа үйлийг хийх явцдаа сурч, мэддэг онцлогтой нийцэж байна.

Харин суурь боловсролд шинжилгээ/судалгаа хийх, бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд ашиглагдах боломжтой байна. Эдгээр нь эссэ бичих, хэлэлцүүлэг хийх, дурд тоглох, экскурс, аялал хийх зэргээр хэрэгжих боломжтой юм.

**Хүснэгт 4.6.2. Урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт ба ТХЗ-ыг хангах сургалтын арга**

Боловсролын түвшин	Арга зүй				Суурь			
	Бага		Суурь		Бага		Суурь	
Цогц чадамж	Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд	Шинжилгээ/судалгаа хийх аргууд	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд	Алсын хараатай болох аргууд	Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд	Шинжилгээ/судалгаа хийх аргууд	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд	Алсын хараатай болох аргууд
Хөгжим	4	-	6	1	3	6	6	-
Дүрслэх урлаг	-	6	5	1	3	5	4	-
Дизайн- технологи					5	4	2	4
Нийт	4	6	11	2	11	15	12	4

Тухайн судлагдахууны болон суралцахуйн зорилтын онцлогоос хамааран нэг суралцахуйн зорилтод 1-2 хүртэл төрлийн арга хэрэглэх боломжтой бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөрийн бүтээлч эрэлхийллийн арга барил эзэмшүүлэхэд чиглэгдсэн аргазүй, аргатай нийцэж байгаа юм.

Үүнээс гадна Дүрслэх урлаг - технологи хичээлийн хувьд ТХЗ-ын суралцахуйн нэг зорилт, сэдэвт хамаарах судлагдахууны хэд, хэдэн суралцахуйн зорилт гарч ирсэнтэй холбоотой 8 дугаар багана буюу аргын сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар, үндэслэлийг ялгаатай байдлаар бичих боломжгүй байсан. Учир нь тухайн судлагдахууны онцлогтой холбоотойгоор сонгон хийх бүтээл, хийх арга технологи, хэрэглэх багаж, материал, хэрэглэгдэхүүнээс хамааран агуулгын өргөсөл, гүнзгийрэл тодорхойлогддог. Иймээс ерөнхий арга зүйг ялгаатайгаар томъёолох боломж харагдахгүй байна гэж үзээд ижил томъёололтой суралцахуйн зорилтуудын 8 дугаар багана буюу “аргын сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар” гэсэн нүдийг нэгтгэн тайлбар бичсэн болно. (матриц 2-оос дэлгэрүүлж үзнэ үү)

Шинжилгээнээс үзэхэд тогтвортой байдлын цогц чадамжийг сурагчдад эзэмшүүлэхэд урлаг, дизайн технологийн хичээл дараах байдлаар хувь нэмэр оруулах боломжтой байна. Үүнд:

**Хүснэгт 4.6.3. ТБ-ын цогц чадамжийн төлөвшилд урлаг, дизайн технологийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын оруулах хувь нэмэр**

Цогц чадамж	Бага боловсрол		Суурь боловсрол			Нийт
	Хөгжим	Дүрслэх, дизайн технологи	Хөгжим	Дүрслэх урлаг	Дизайн технологи	
1. Тогтолцоот сэтгэлгээний		4	2	4	4	14
2. Урьдчилан тооцоолох	1		1		2	4
3. Хэм хэмжээний			1	1	1	3

4. Стратегийн					2	2
5. Хамтран ажиллах	1	2	1	1	2	7
6. Шүүмжлэлт сэтгэлгээний	3	3	1	2	1	10
7. Өөрийгөө таньж мэдэх	2	2	1	4		9
8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн					1	1
Нийт	7	11	7	12	13	50

- Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж: Урлаг, дизайн технологийн хичээлээр тогтолцоот сэтгэлгээг хөгжүүлэх нь сурагчдад аливаа зүйлийн харилцан хамаарлыг танин мэдэж ойлгох, тэдгээрийг хэрхэн уялдан нэгдсэн тухай сэтгэн бодох чадварыг хөгжүүлснээр орон нутаг, улс үндэстэн, дэлхий нийтийн ТХ-ийн зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.
- Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж: Тогтсон хэм хэмжээ, дадал туршлага, санаа бодолдоо тулгуурласан асуудал дэвшүүлэх, өөрийн үйл хөдлөлөө эргэцүүлэн бодох, тогтвортой байдлын тухай хэлэлцүүлэгт өөрийн байр сууринаас хандах зэрэг чадваруудыг энэ цогц чадамжид хамруулж үздэг. Урлаг, дизайн технологийн хичээлүүд нь сурагчдын бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн төсөлт ажил гүйцэтгэх, өөрийн үзэл бодлоо бүтээлдээ тусгаж, үнэт зүйлийг бий болгож, эзэмшиж байдаг, өөрийгөө илэрхийлэх, бусдыг сонсох, хүндэтгэх зэргээр ТХ-ийн цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулдаг учраас суралцахуйн зорилт харьцангуй олон байна.
- Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж: Энэ цогц чадамжийн хүрээнд дэлхийн болон орон нутгийн түвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох, хэн нэгний үйл хэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх, урам хайрлах, мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх чадварыг багтаадаг. Урлаг, дизайн технологийн хичээл хүний үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөө, тэдгээрийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд өөрийн үүрэг оролцоо чухал болохыг бүтээлээрээ дамжуулан үзүүлэх боломжтой учраас энэ цогц чадамжид хувь нэмэр оруулах боломжтой гэж үзсэн. Урлаг, дизайн технологийн судлагдахуунаар боловсруулсан нэгж хичээлийн товчоог Хүснэгт 4.6.4-д үзүүллээ.

**Хүснэгт 4.6.4. Урлаг, дизайн технологийн судлагдахууны нэгж хичээлийн товчоо**

Түвшин	Хичээл	Анги	Сэдэв	Хичээлийн зорилго, агуулга	Боловсруулсан
Бага боловсрол	Хөгжим	III	Ус амьдралыг тэтгэгч /Ногоон дэлхийгээ аварья!	Суралцагч урлагийн бүтээлүүдээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, өөрийнхөөрөө дүрслэн бодож харьцуулдаг болно.	Халтарын Энхжаргал (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан)
	Дүрслэх урлаг	V	Эрүүл зөв хооллолт ба өглөөний зууш	Эрүүл зөв хооллолт болон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарын талаар судалж өглөөний хоол бэлтгэж суна.	Сияатовын Отгонтуяа (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан)



Суурь боловсрол	Хөгжим	IX	Уур амьсгалын өөрчлөлт /Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг/	Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах явцдаа уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, урьдчилан сэргийлэх арга замыг эргэцүүлэн бодож чаддаг болно.	Халтарын Энхжаргал (БХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан)
			Дүрслэх урлаг	VIII	Монголын орчин үеийн уран бүтээлчдийн зураг бүтээлтэй танилцах
	Дизайн-технолог	VI			Хэрэгцээ ба ашиглалт

**Хүснэгт 4.6.5. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсрол: Хөгжим)**

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
1. Соёлын үнэт зүйл	1,3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах-"Шүдээ хайрлая, шүдээ угаацаая"	ТХ303.3Y1	ТХ33. Сэ3
1. Соёлын үнэт зүйл	1,3.3 Хөгжмийн урлагийг ойлгосноор дэлхийн болон ардын урлагийн өв сан, үнэт зүйлсийг хүндлэх, бишрэх, хамгаалах-"Номын нөхөр болоорой"	ТХ304.ТМ4	ТХ34. Сэ5
1. Урлагийн хэл	1,1.4 Хөгжмийн бүтээлийн утга агуулга, дүр дүрслэлээс хурд, хүчний үүргийг ойлгох, илэрхийлэх-"Цэвэр гар"	ТХ303.3Y1	ТХ33. Сэ1
2. Урлагийн хэл	2, 2.5 Аялгууны шинж төрхийг ойлгох, сонсож таних, тодорхойлох, ялгах, тайлбарлах-"Хувдай ишигний паян"	ТХ311.ТМ3	ТХ311. Сэ5
3. Соёлын үнэт зүйл	3, 3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах-"Ногоон дэлхийгээ аваръя"	ТХ313.НСХ1	ТХ313. Сэ11
4. Гоо сайхны илэрхийлэл	4, 2.1 Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг график дүрслэлээр зурах, бичих, жүжигчлэн тоглох-Д.Дашням "Хиросимо охины цаасан шувуу"	ТХ316.НСХ3	ТХ316. Сэ6
5. Соёлын үнэт зүйл	5,3.1 Өөрийн орны болон гадаадын хөгжмийн зохиолчдын бүтээлтэй танилцах, сэтгэгдлээ ярилцах- Ж.Чулуун "Уулын горхи"	ТХ306.НСХ3	ТХ36. Сэ6

**Хүснэгт 4.6.6. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Суурь боловсрол: Хөгжим)**

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
8. Зохион найруулах	8, 4.3. Сонгодог хөгжмийн бүтээлийг театрт болон дүрс бичлэгээс үзэж сонсох, өөрийн байр сууринаас санаа бодлоо хуваалцана.- К.Дебюсси "Тэнгис" симфони чуулбар	ТХ306.НСХ3	ТХ306. Сэ06.
9. Зохион найруулах	9, 4.1. Орчин үеийн хөгжмийн зохиолчдын бүтээлийн агуулга дүрийг янз бүрийн арга хэрэглүүр ашиглан, өөрийн санаагаар баяжуулах, хувиргаж илэрхийлнэ. - С.Стравинский "Ариун хавар" бүжгэн жүжиг	ТХ315.НСХ5	ТХ315. Сэ4.
9. Зохион найруулах	9, 4.3. Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах явцдаа өөрсдийн авьяас, туршлагаадаа тулгуурлан хувилбар боловсруулах Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг	ТХ304.ТМ1	ТХ34. Сэ8.
9. Танин мэдэх	9, 01.1. Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл, хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлт, тэдгээрийн онцлогийг мэдэрч, ойлгон, хэрэглэнэ.- Ш.Өлзийбаяр "Дөрөө" модерн бүжгэн жүжиг	ТХ303.НСХ4	ТХ33. Сэ5.
9. Хөгжимдөх	9, 3.1. Хөгжмийн бүтээлийг сонирхон судлах замаар орчин үеийн хөгжмийн зохиолчдын арга барил, бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, задлан шинжлэл хийх, сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваалцана. С.Сансаргэрэлтэх - "Эх дэлхийгээ аварцгаая"	ТХ313.НСХ3	ТХ313. Сэ3.

**Хүснэгт 4.6.7. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга (Бага боловсрол: Дүрслэх урлаг, технологи)**

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
5. Урлагийн хэл	5, 01.14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх	ТХ303.3Y1	ТХ303. Сэ09.
4. Урлагийн хэл	4, 01.14. Ажил мэргэжлийн талаар ойлголттой болох	ТХ308НСХ4	ТХ308. Сэ01.
5. Гоо сайхны илэрхийлэл	4, 02.15. Хаягдал материал ашиглан бүтээл хийх	ТХ3123Y1	ТХ312. Сэ07.
5. Соёлын үнэт зүйл	5, 03.5. Монголын болон гадаадын уран зураачдын уран зураг унших	ТХ311.ТМ3	ТХ311. Сэ05.
3. Гоо сайхны илэрхийлэл	3, 02.4. Бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал багаж хэрэгсэл сонгох, ашиглах	ТХ312.ТМ4	ТХ312. Сэ02.
3. Гоо сайхны илэрхийлэл	3, 01.9. Байгалийн материалыг (шарлаж унасан навч, чулуу, хугарч унасан мөчир, боргоцой гэх мэт) баримлын шавраар холбох аргаар биет тоглоом бүтээх	ТХ315.НСХ3	ТХ315. Сэ08.

**Хүснэгт 4.6.8. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга**  
(Суурь боловсрол: Дүрслэх урлаг, технологи)

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
Бүтээл илэрхийлэл	8, 03.1. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн бүтээлтэй танилцах, эргэцүүлэн бодох, асуудал дэвшүүлэн хэлэлцэх	ТХ311.ТМ3	ТХ311. Сэ05.
Бүтээл илэрхийлэл	8, 03.2. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлтэй танилцах, эргэцүүлэх, асуудал дэвшүүлэн хэлэлцэх	ТХ304.ТМ4	ТХ304. Сэ08.
Урлан бүтээхүй	8, 02.16. Ахуйн хаягдлыг бусад төрлийн материалтай хослуулан чимэглэл хийх	ТХ312.НСХ1	ТХ312. Сэ07.
Урлагийн хэл	6, 01.8. Амьтны биеийн бүтцийг баримжаалан дүрсэлж сурах	ТХ315.ТМ1	ТХ315. Сэ08.
Урлан бүтээхүй	7, 02.12. Байгалийг бодит байдлаас харж зурах	ТХ315.НСХ3	ТХ315. Сэ08.
Урлагийн хэл	8, 01.8. Хүн ба амьтны судалбар зурах	ТХ315.НСХ4	ТХ315. Сэ08.

**Хүснэгт 4.6.9. Цөм хөтөлбөрийн ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт, агуулга**  
(Суурь боловсрол: Дизайн, технологи)

Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	ТХБ	
		ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв
1	2	3	4
6. Боловсруулах технологи	6.02. 4. Уламжлалт гар урлалын технологитой танилцах суралцах, материал сонгохдоо байгалийн болон нийлмэл материалын гарал үүсэлтэй холбоотой мэдээлэл, мэдлэг ойлголтоо ашиглах, технологийн эерэг сөрөг нөлөөний талаар өөрсдийн бодлоо хуваалцдаг	ТХ309.ТМ5	ТХ309. Сэ04.
6. Боловсруулах технологи	6.02. 1. Өөрийн болон өрх гэр, хамт олны хүрэн дэх асуудлаас хэрэгцээг олж харах, түүнийг шийдэх эдийн засгийн шинэ санаа олох, зохион бүтээх ажилтай холбогдох мэдээлэл цуглуулж, эд зүйлсийн дизайны элементүүд, хэлбэр хэмжээ, өнгө, чимэглэл, шинжилгээ хийх замаар санаагаа сайжруулах	ТХ308.ТМ3	ТХ308. Сэ10.
6. Дизайн зураг зүй	6. 01. 4. Материалын гарал үүсэл, нөөц, үйлдвэрлэл, түүнийг дахин боловсруулах үйл явцын талаар судлах, хэлэлцэх эргэцүүлэх замаар хэмнэлттэй хандах хандлагыг нэмэгдүүлнэ	ТХ308.НСХ1	ТХ308. Сэ02.
6. техник	6.03. 4. Хэрэглээнээс гарсан дахин ашиглах боломжтой материалуудыг сонгон ашиглах, хэрэгцээт эд зүйлс хийх, бүтээх хандлагатай болно.	ТХ312.НСХ1	ТХ312. Сэ07.

7. Дизайн зураг зүй	7.01. 4. Хэрэглээнээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах. Хэрэгцээг өрнүүлэх замаар хэрэгцээт зүйл бүтээх хандлагыг нэмэгдүүлэх	ТХ312.3Y5	ТХ312. Сэ07.
7. Боловсруулах технологи	7. 02. 1. Өөрийн болон өрх гэр, хамт олон, олон нийтийн хүрэн дэх асуудлаас хэрэгцээг илрүүлж, эдлэл зохион бүтээх санаа олох, зохиомжийн аргууд, хийх арга барилтай холбоотой мэдээлэл цуглуулан дизайнд шинжилгээ хийж санаагаа сайжруулан, дүрслэлийн дүрэм стандартыг баримтална.	ТХ304.НСХ4	ТХ304. Сэ07.
7. Боловсруулах технологи	7. 02. 4. Технологи ажилбарын үед гарсан хог хаягдлыг ангилах дахин ашиглах боломжтойг ялгах, ажлын байрны эмх цэгц аюулгүй байдлыг ханган ажиллах	ТХ303.3Y1	ТХ303. Сэ10.
7. Дизайн зураг зүй	7, 02. 1 Хамт олон өрх гэрийн хүрэн дэх асуудлаас хэрэгцээг илрүүлнэ.	ТХ312.НСХ2	ТХ312. Сэ08.
7. Дизайн, зураг зүй	7. 01. 1. Асуудлыг шийдвэрлэхдээ олон төрлийн эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж судалгаа хийнэ. Зохион бүтээх болон загварчлалын аргуудыг ашиглан эдлэлийн загвар зохиох	ТХ304.НСХ3	ТХ304. Сэ06.
8. Боловсруулах технологи	8.02. 2. Уламжлалт болон орчин үеийн технологийг хослуулан бүтээгдэхүүний санаа, шийдэл олох, түүний ажлын болон тойм зураг, илэрхийлэхдээ зурагзүйн дүрэм стандартыг баримтлан зурах, хэсэгчилсэн огтлол, зүсэлтээр зурж үзүүлэх, эсгүүрийн зураг байгуулах материалын шинж, уран сайхны боловсруулалт хийх, оёдлын болон мод, металлын боловсруулах тусгай зориулалтын багаж, тоног төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон материалыг боловсруулах талаар мэдлэг ойлголттой болох.	ТХ317.3Y2	ТХ317. Сэ06.
8. Дизайн, зурагзүй	8.01. 4. материал багаж, хэрэглэгдэхүүнийг сонгох, бүтээхдээ байгал орчинд аюулгүй талаарх ойлголтыг авч үзэх, хэрэгжүүлэх хандлагатай болно.	ТХ315.НСХ4	ТХ315. Сэ08.
8.Боловсруулах технологи	6. 02. 2. хүнсний төхөөрөмж, гар багажны төрөл, зориулалт, хэрэглээ аюулгүй ажиллагааны талаар мэдлэг ойлголттой болох	ТХ304.ТМ1	ТХ304. Сэ06.
8.Боловсруулах технологи	8. 02. 1. Цагаан идээ боловсруулах арга технологиос суралцах, ойлголттой болно.	ТХ302.3Y5	ТХ302. Сэ05.

**4.6.2. Бага боловсролын хөгжмийн хичээл**

**4.6.2.А. Бага боловсролын хөгжмийн хичээлээр ТХБ-д оруулах хувь нэмэр**

**Үндэслэл**

Тогтвортой хөгжлийн боловсролоор хүмүүсийн мэдлэг, чадвар, хандлага, үйлдэл, үнэ цэнийг өөрчлөхийг зорьдог тул урлагийн хичээлийн хөтөлбөрийн агуулгад энэхүү үзэл санааг хэрхэн, яаж тусгаж оруулах вэ? гэдэг асуудал гарч ирж байна.

Өөрийн орны болон дэлхийн хөгжмийн зохиолчдын уран бүтээлээр дамжуулан байгаль орчин, ус, тогтвортой хэрэглээ, соёл хоорондын харилцан ойлголцол, соёлын

ялгаатай байдал, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийг бүхэлд нь багтаан, харилцан хамааралд нь ойлгуулж, суралцагчдыг тогтвортой хөгжлийн боловсролтой иргэн болгож төлөвшүүлэхэд хөгжмийн хичээлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол их юм.

Урлагийн аль ч хичээлийн төлөвлөлтөд тогтвортой хөгжлийн үзэл санааг дараах байдлаар тусгаж болно. Үүнд:

- Тогтвортой хөгжилд хамааралтай чадварыг тодорхойлж, сурагчдад эзэмшүүлж, хөгжүүлэхэд анхаарна. Жишээ нь: Сурагчдын ирээдүйг төсөөлөн харах чадвар, асуудал юмсын холбоо хамаарлыг ойлгох, хүлээж авах, шийдвэр гаргахад оролцох, асуудал шийдэх, хамтран ажиллаж нэгдсэн нэг шийдэлд хүрч чаддаг байх, асуудал, юмс үзэгдлийг цогцоор харах, шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн боддог байх.

Түүнчлэн сургалтын хөтөлбөрийн арга зүй нь шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг энгийн ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэхэд чиглэсэн байна. Сурагч өөрийн үйл ажиллагаагаар мэдлэг бүтээхэд хөтөлсөн орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүснэгт, график, бүдүүвч, зураг, бичвэрийг оновчтой сонгох шаардлагатайг анхаарах нь зүйтэй.

#### Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал

Ерөнхий боловсролын сургалтад ТХБ-ын интеграцчилах багшид зориулсан гарын авлагын хүрээнд “Хөгжим”-ийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг ТХ-ийн 17 зорилготой уялдуулахын тулд дараах байдлаар шинжилгээ хийсэн болно. Шинжилгээ хийхдээ:

- Тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэглэгдэхүүн буюу урын сангийн жагсаалтыг гаргаж, түүн дээр тулгуурлан ТХ-ийн зорилгыг сургалтын хөтөлбөрийн зорилттой уялдуулах оролдлого хийсэн болно.
- ТХЗ-ын сурагчдад эзэмшүүлэх үйл буюу чадварыг суралцахуйн зорилтын танин мэдэхүйн үйлтэй холбохыг оролдсон.

Тогтвортой хөгжлийн зорилго, хөгжмийн хичээлийн суралцахуйн зорилтын хамаарлыг шинжилж үзэхэд бага боловсролын түвшинд нийгэмшил, сэтгэл хөдлөл болон зан үйлийн зорилт түлхүү байсан бөгөөд шинжилгээний үр дүнг хүснэгтээр харуулбал:

ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт

Ай	Танин мэдэхүйн	Нийгэмшил, сэтгэл хөдлөл	Зан үйл	Нийт
Суралцахуйн зорилтын тоо	1	4	2	7

Бага боловсролд тогтвортой хөгжлийн “Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох” зорилгыг сургалтын хөтөлбөрийн “Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах” зорилттой уялдуулахдаа тайлбарлаж чаддаг болох- тайлбарлах, харьцуулах гэсэн үйл үгээр нь холбож сонгосон болно. Эдгээр зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд “Ногоон дэлхийгээ аваръя” зохиол гол хэрэглэгдэхүүн болно.

#### Суралцахуйн зорилт, агуулга, арга зүйн интеграцын тодорхойлогдсон байдал

ТХЗ-ыг хэрэгжүүлэх арга зүйг суралцахуйн зорилтын хүрээнд хийх үйл ажиллагаатай холбож сонгосон болно. Бага боловсролд бодит үйл ажиллагаанд оролцох, бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх арга зүй голлох бөгөөд экологийн тэнцвэр алдагдах хүчин зүйлсийн нэг нь хувь хүмүүсийн ёс зүй бөгөөд экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж, өөрийнхөөрөө дүрслэн бодож, харьцуулдаг болоход “Ногоон дэлхийгээ аваръя” бүтээл чухал ач холбогдолтой болно.

Арга зүйн төрлийг сонгосон байдал (давхардсан тоогоор)

Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох аргууд	Шинжилгээ/ судалгаа хийх аргууд	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд	Алсын хараатай болох аргууд
2	0	4	1

esd.itpd.mn

Хүснэгт 4.6.10. Сурагчдын зорилт арга зүй, цоц чадмжийн интеграл (Бага боловсрол: Хөгжим)

Цөц чадмж	Арга зүй	Цоц чадмж	ТХБ					Анги
			1	2	3	4	5	
Үндэслэл, тайлбар	Аргыг сонсох үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар/сурагчдын үндэслэл, сурах бичиг, бусад	Код	Үндэслэл, тайлбар					
6-шүүмжлэлт сэтгэлгээний цоц чадмж. Урлагийн бүтээлүүдээр дамжуулан урлг амьдралын зан төлөвийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх, үйл хөдөлгөө эргэцүүлэн бодох учраас	3-р арга зүйн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөө дүрслэн бодож, тайлбарлах, харьцуулах үйл ажиллагаанд оролцох учраас эгзгэрт тохирох аргуудыг тооцож боловсруулна.	9	Эрүүл мэнд болон сайн сайхан амьдралыг дэмжих гол стратегиудад эрүүл мэндийн зөвлөгөө, боловсрол, дадал, үйл ажиллагаа, сурагчдын эрүүл амьдралын зан төлөвийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж сурахад холбоотой юм.					
7- өөрийгөө таньж мэдэж, соёлын үүрэг, ач холбогдлыг ойлгож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох тул.	хүндлэх, бичрэх, хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дэлхийн болон ардын урлагийн үндэслэл, үйл ажиллагаанд оролцох учраас 3-р арга зүйг сонгож, түүнд тохирох аргуудыг тооцож боловсруулалт хийнэ.	6	Хүн амыг бичиг үсгийн боловсролтой болгоход соёл чухал үүрэгтэй болохыг ойлгож, өшөрөн, хамгаалах бөгөөд дэлхий даяар өдөр тутмын амьдралд үндсэн үйл ажиллагаанд оролцох үүрэг нь улс орны хөгжилд нөлөөлдөг талаар ойлголт мэддэгтэй холбоотой болно.					
6- шүүмжлэлт сэтгэлгээний цоц чадмж. Тогтсон хэм хэмжээг дадал, хэвшил болгох, үйл хөдөлгөө эргэцүүлэн бодох тул.	ойлгож, илэрхийлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөгжмийн бүтээлийг сонсож, өөрийнхөө илэрхийлэх учраас 1-р арга зүйг сонгож боловсруулалт хийнэ.	7	Гар, амны эрүүл ахуйн буюу хэвшил нь халдварт болон халдварт бус өвчний гол суурь нь болдог учраас эрүүл амьдралын зан төлөвийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж сурахад Цэвэр гар дуу холбоотой болно.					

2. 2.5 Аялгууны шинж төрхийг ойлгож, сонсож таньж, тодорхойлох, ялгах, тайлбарлах. Хувьд илшнийг пант	Мөнөй үлс сүүлгийн жилүүдэд нүүдлийн соёл иргэншлээс бүрэн соёл иргэншилд шилжих болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор суурьшлын хав маягийн түүхэн шалтгааныг ойлгож, соёлын өв уламжлалыг хүндэтгэх, ялгах, хотын зохиолчлолын өрнөх хийж үйлдэх, эрүүл ахуйн талаарх байгаа тухай тайлбарлах, тогтвортой тогтолцоог хөгжүүлэх зөвшилцөлд хүрэх шаардлагатай ойлгоход холбоотой болно.	7	Тодорхойлох, ялгах, тайлбарлах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд заавал задлан шинжилгээ хийж асууулыг таньж тодорхойлох, улмаар шалтгаан-ур дагаарыг тооцоолож ойлгож тайлбарлах учраас 2-р арга зүйг сонгож, түүнд тохирох аргуудыг тооцож, өөрийнхөө үйл ажиллагаанд оролцох учраас 4-р арга зүйг сонгож, түүнд тохирох аргуудыг тооцож боловсруулалт хийнэ.	7	7-тогтолцоот сэтгэлгээ: хотын экологи болон онгон байгаль хүний суурьшилд, дэсан зохиож, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэн бодох, асуудлыг тайлбарлах, тул.
3. 3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, тайлбарлах, харьцуулах. Ногоон дэлхийгээ авьяр	Экологийн тэнцвэр алдагдах хүчин зүйлс бөгөөд эхос системийн үйлдэл өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлах, өөрийнхөөрөө дүрслэн бодох, харьцуулахад болоход Ногоон дэлхийгээ авьяр бүүгээл	6	Тайлбарлах, харьцуулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд урлагийн бүтээлүүдийг сонсоод ойлгож, харьцуулах үйл ажиллагаанд оролцох учраас 4-р арга зүйг сонгож, боловсруулалт хийнэ.	6	6-шүүмжлэлт сэтгэлгээ: Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлах, асуудал дэвшүүлэх тул.
4. 2.1 Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг графика, дүрслэлээр зурах, бичих, хөгжүүлэн тоглох- ДД-дэнийн хөгжмийн охины цаасан шувуу	Дэлхий нийтэд дайн дажингүй, энх тайван байх нь чухал болохыг ойлгож, Түүнээс улбаатайгаар өөрийн болон бусад улс орнод шударга бус байдлаас болон зөвхө шаналж байгаа хүмүүсийг ойлгож, эв найрамдал, тэнцвэртэй байдалд Хорсооно охины цаасан шувуу дуу холбогдох болно.	5	Үйл ажиллагаанд оролцох, хамгаалахад эрэлж, сонгож бөгөөд Тухай бүтээлийн агуулга, дүрийг графика дүрслэлээр зурах, бичих, хөгжүүлэн тоглох аргудаас сонгон боловсруулна.	5	5- хамтран ажиллах: Дэлхий нийтэд дайн дажингүй, энх тайван байх нь чухал болохыг ойлгож, оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд тул.
5. 3.1 Өөрийн орны болон гадаадын хөгжлийн зан чиглэл, зохиолчдын бүтээлээр дамжуулан явдал ойлгож, урьдчилан сэтгэлгээг тайлбарлах. Ж- Чулуун "Уулын горхи"	Усны зохиогчийг хэрэглээ нь хөрс, усны бохирдол, экологийн тэнцвэрт байдал алдагдах хүчин зүйлсийн нэг учраас усны зохиолчийн хэрэглээ болон усны хомсжилт талаар ойлгож, сэтгэлгээг яригцаж, харьцуулахад харьцангуй хариуцаж болно.	2	Өөрийн орны болон гадаадын хөгжмийн зохиолчдын бүтээлийн талаар хэлэлцүүлж, ялах, дүрд зураж, тоглох. Ур-баас-с-р төрлийн арга зүйг сонгож боловсруулна.	2	2- урьдчилан тооцоолох: хөгжмийн зохиолчдын бүтээлээр дамжуулан явдал ойлгож, урьдчилан сэтгэлгээг тайлбарлах, оролцоонд тул.



**4.6.2.Б. Нэгж хичээлийн жишээ: 3-р анги**

*Нэгж хичээлийн сэдэв: Ус амьдралыг тэтгэгч*

*Нэгж хичээлийн зорилго:* Суралцагч урлагийн бүтээлүүдээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, өөрийнхөөрөө дүрслэн бодож харьцуулдаг болно.

*Хүрэх үр дүн:* Хувь хүмүүсийн ёс зүй нь экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг болохыг ойлгож, тэдгээрийг урлагийн бүтээлүүдээр дамжуулан мэдрэх, ойлгох, дүрслэн бодоход дэмжлэг үзүүлнэ.

*Нэгж хичээлээр ТХБ-д хувь нэмэр оруулах үндэслэл*

ТХБ-ыг эзэмшүүлэхэд чиглэсэн арга зүйг сонгох, өөрөө түүнд суралцах нь багш бүрийн хувьд нэн чухал юм.

Багш хичээл болон заах арга барилаа эргэцүүлж, хичээлийн аль хэсэгт байгаль орчин, нийгмийн асуудлыг тусгаж болохоор байна вэ? гэдгийг бодох хэрэгтэй юм. Жишээ нь: Хөгжмийн талаар сурагчид өөрсдийн үзэл бодлоо тусгаж харьцуулалтын аргыг ашиглана. Дараа нь дэлхий ертөнцөд хөгжмийг хэрхэн ойлгож байна вэ? Соёлын болоод газарзүйн хувьд ялгаатай хөгжмийн хоёр жишээг танилцуулна. Сургалтын явцад хөгжмийн бусад үйл ажиллагаатай нэгтгэж болно.

Урлагийн олон талт үйл ажиллагааг бие даасан болон хамтарсан хэлбэрээр гүйцэтгэх ба мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэхэд чиглэсэн дасгал, даалгаврыг боловсруулах, даалгаврын тавил нь тэдэнд хийж бүтээх сэдэл сонирхлыг төрүүлсэн, бүтээлч үйлд хөтөлнө.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХ-ийн зорилго, сэдэвт харгалзах байдал (матриц 1-ээс)*

	ТХ313.Сэ11. Ёс зүй ба уур амьсгалын өөрчлөлт
ТХ313.НСХ1. Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох	3, 3.2 Хөгжмийн урлагийн хүрээнд урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, тайлбарлах, харьцуулах 

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэл*

ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв	Үндэслэл, тайлбар
4	5	6
ТХ313.НСХ1	ТХ313.Сэ11	Экологийн тэнцвэр алдагдах хүчин зүйлсийн нэг нь хувь хүний ёс зүй бөгөөд экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж, өөрийнхөөрөө дүрслэн бодож, харьцуулдаг болоход Ногоон дэлхийгээ аварья бүтээл холбогдоно.

*Арга зүй сонголт:* Шинжилгээ /судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах)

Тайлбарлах, харьцуулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд урлагийн бүтээлүүдийг сонсоод ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох, хэлэлцүүлэх учраас бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээний арга зүйг сонгосон. Энэ нь сургалтын цөм хөтөлбөрийн хүүхдийн хэрэгцээ, сонирхол, туршлага, чадварт суурилж, тэдний бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх, хүүхэд бүр ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээнд оролцох, дүрд тоглох, хамтаар дасгал, бодлого, сорил, даалгавар гүйцэтгэх зэргээр хамтран ажиллах болон оролцооны арга барилд суралцахтай уялдуулан хэрэгжүүлэх боломжтой.

*Тогтвортой байдлын цогц чадамж*

ТБ-ын цогц чадамжууд нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт болон ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд суралцагчийн танин мэдэхүйн, хэл-нийгмийн, амьдрах ухааны чадамжийг хөгжүүлж, тэдгээрт харгалзах ерөнхий чадвар болон сурах арга барил эзэмшихэд хувь нэмэр оруулна. Үүнд: 6 шүүмжлэлт сэтгэлгээ: урлагийн бүтээлүүдийг ойлгож, өөрийнхөөрөө дүрслэн бодох

*Бага боловсролын түвшинд сурагчид:*

- Хүний болон хүрээлэн буй орчинд хувийн хариуцлагыг ухаарч, холбогдох талуудыг хүлээн зөвшөөрөх;
- Харилцах, хамтран ажиллах замаар нийгэм-соёлын саад бэрхшээл, хувийн ашиг сонирхлыг даван туулахад хувь нэмэр оруулах;
- Олон улсын өөрчлөлт, ялангуяа хувийн болон мэргэжлийн салбарт шинэлэг болон нээлттэй нөхцөл байдлыг нийгэмд бий болгох;
- Сурагчид өөрсдийн бие даасан шийдвэрийг үндэслэн, хувийн хэвшил, сургууль, мэргэжлийн салбарт тогтвортой хөгжлийг хангах зорилтыг хэрэгжүүлэх, нийгэм, улс төрийн үйл хэрэгт оролцох чадвартай болно.

## Нэгж хичээлийн төлөвлөлт

Судлах цаг: 2 цаг - 80 мин

Ээлжит хичээл 1

## Алхам 1.

- Аяллаар хөдөө явцгаая.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Байгалийн дуу чимээ (гол урсах, шувууд жиргэх, хонь, ямаа майлах)
- Энэ юуны дуу чимээ вэ? яаж таньсан бэ?
- Багш сурагчид хөдөө нутгаар аялж буй дүрслэлийг илэрхийлэн дүрд хувирч жүжиглэнэ.

**Алхам 2.** Сурагчдад “Ногоон дэлхийгээ аваръя” зохиолыг сонсоно. Хөгжмийн зохиолыг сонсохын тулд юуны өмнө сонсох бэлтгэлийг хангана. Үүнд:

- Нам гүм орчныг бий болгох,
- Анхаарлаа төвлөрүүлж сонсохыг сануулна,
- Хөгжмийн чанга, сул хүчийг тохируулах (намуухан),
- Боломжтой бол уран зураг харж төсөөлөх.



**Алхам 3.** Багш хөгжмийг 2-3 удаа сонсоод дараах асуултын дагуу сурагчидтай ярилцана.

Асуулт:

- Хөгжимд ямар ямар дүр гарсан бэ?
- Аялгууны шинж төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
- Байгаль яагаад үнс, нурам болов?
- Байгалийн сүйрлийг хөгжмөөр хэрхэн илэрхийлж байна вэ?
- Байгалийг сэргээж амь оруулахад юу тусалсан бэ?

**Алхам 4.** Зохиолын дүрүүдийн өнгө аяс, эгшиглэх хүч, хурд, агуулгын талаар сурагч бүр бодож эргэцүүлээд, дэвтэртээ дараах чиглэлээр бичих даалгавар өгнө.

	Мөсөн уул	Сүйрэл	Ногоон гараг
Хурд			
Хүч			
Өнгө аяс			
Агуулга			

**Алхам 5.** Сурагч бүр өөрсдийн бичсэнээ хамт суугаа найздаа танилцуулж, ус яагаад чухал болох талаар харилцаж, санал солилцоно. Жишээ нь:

- Усыг хайр гамгүй хэрэглэвэл бидэнд ямар аюул тулгарах вэ?
- Хүн амин хувиа хичээвэл байгаль орчинд ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ?
- Бид усны хэрэгцээгээ хэрхэн яаж зохицуулах ёстой гэж бодож байна вэ?

**Алхам 6.** Сурагчид 5-8 хүний бүрэлдэхүүнтэй багт хуваагдана. Сурагч бүр өөрсдийн бичсэнээ бусад сурагчдын бичсэнтэй нэгтгэж багийн дүгнэлт гаргана.

## Ээлжит хичээл 2

Хөгжим нь зохиолын утга санаа, үйл хөдлөл, гол баатруудын бодол санааг үзэгчдэд хүргэхэд гол үүргийг гүйцэтгэдэг тул бүтээлчээр сэтгэх, эрэл хайгуул хийлгэх зорилгоор энэ сэдвийн хүрээнд сурагчдаар дараах үйл ажиллагааг хийлгэж болно. Тухайлбал: үйл явдлын ард хөгжмийн чимэглэл хийх, үйл явдалд хүч оруулах, дуу авианы сонголт хийх, турших гэх мэт

**Алхам 1.** Сурагчдад зохиолын үйл явдалтай холбоотой 2-оос доошгүй асуулт зохиох даалгавар өгнө.

**Алхам 2.** Асуулт зохиосны дараа сурагчдыг 2-3 багт хувааж, өөрсдийн багийн зохиосон асуултуудыг “Энэ асуултын хариулт аялгууны аль хэсэгт байна вэ?” гээд зохиолын үйл явдлын дагуу эрэмбэлэх даалгавар өгнө.

**Алхам 3.** Эрэмбэлсний дагуу хөгжмөө дахин сонсоно. Зохиолыг сонсох үедээ сонсон хэсгийнхээ талаар тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэл хийхдээ дараах алхмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Сонссож буй хөгжмийнхөө зохиогч, зохиолын нэрийг бичнэ.
- Хөгжмийн зохиолын ямар төрөл зүйлд хамаарах вэ? (дуулаач, дан хөгжим эсвэл дуу, бүжиг, марш гэх мэт)
- Хөгжмийн ямар зэмсгээр хөгжимдсэн бэ? (ардын хөгжим, симфони оркестр, төгөлдөр хуур, нарийн бүрээ, морин хуур гэх мэт)
- Аялгууны шинж төрх, онцлогийг үгээр болон график зураглалаар зурж тэмдэглэх /эрчилсэн, намуун, тайван, тасралтгүй, нэгэн хэвийн, огцом, эрс тэс, эмзэг, тогтворгүйтэх мэт/
- Хөгжмийн зохиолын агуулга, дүрийн талаар өөрийн төсөөллөө бичих эсвэл зурж тэмдэглэх, өөрийн санал сэтгэгдлийг оруулах
- Зохиолын агуулга, утга санааг өөрийн амьдрал туршлагатай холбож тэмдэглэх

**Алхам 4.** Энэ сэдвийн дагуу сурагчид баг багаараа өөрсдийн дуулах, сонсох дуртай дуу хөгжмийн бүтээлд урлагийн бусад төрлүүдийг ашиглан цогц үзүүлбэр бэлтгэн, баг тус бүр нэг номер бэлтгэнэ. Жишээ нь: Өөрсдийн дуулсан дууг ард нь бүжгээр хөдөлгөөнжүүлж, дүрслэх урлагийн бүтээлээр чимж, өгүүлэхүйн урлагийн төрлөөр баяжуулан хүч нэмж болно.

**Алхам 5.** Баг бүр өөрсдийн сонирхсон дуу, хөгжим, бүжиг, хөгжимдөх үйлийн нэг л хэлбэрийг сонгоно. Сонгосон үйлийн хэлбэртээ тохирох нэг уран бүтээл сонгож авна.

**Алхам 6.** Багийн гишүүд хэн, юу хариуцах, хийх талаар ажлаа хуваарилан авна. Багаараа ярилцаж, тоглолтоо бэлтгэнэ.

**Алхам 7.** Баг бүр өөрсдийн бэлтгэсэн нэг цогц үзүүлбэрийг хамт олондоо үзүүлнэ. Анги хамт олноороо сэтгэгдлээ илэрхийлэн санал дүгнэлтээ өгнө.

Эндээс сурагчид урлагийн аль ч төрлөөр амьдралыг уран сайхны аргаар илэрхийлэх нийтлэг шинжтэй гэсэн ойлголтоо бататгаж, тэдгээрийг цогцоор илэрхийлэх боломжтой гэсэн дүгнэлтийг энэхүү ажлаараа дамжуулан ойлгож, гүйцэтгэлийн үр чадвараа хөгжүүлэх боломжтой юм.

**Хэрэглэгдэхүүн:**

- Сурах бичиг, багшийн ном – 3 анги
- Ногоон дэлхийгээ аваръя – зохиолын видео бичлэг
- Хөгжмийн энгийн зэмсэг, даралтат хөгжим
- CD, DVD

**Үнэлэх стратеги, арга, хэлбэр:**

Хөгжмийн хичээлийн үнэлгээ нь сурагчдын сурах үйлүүдийг төлөвлөх, тэднийг төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцох ажлыг зохион байгуулах, хянах, алдаа дутагдлыг цаг тухайд нь засаж залруулах, туслах, зөвлөх, дэмжих гэх мэт үйлүүд байх бөгөөд нөгөө талаас *сурагчдад хөгжмийн ямар мэдлэг хэрэгтэй вэ?, түүнийг яаж эзэмшүүлэх вэ?, хөгжмийн мэдлэгээ өөр нөхцөлд яаж хэрэглэх вэ?, өөрийнхөө мэдлэгийг яаж хянах вэ?, өөрийгөө хэрхэн бодитой үнэлж дүгнэх вэ?* гэх мэт асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн үйлүүдийн нэгдэл байна. Тухайлбал: Ажиглах, сонсох, хэлэлцүүлэх, амаар, бичгээр илэрхийлэх, үйлдэх, үзүүлэх, харуулах /бүтээл хийх, дүрд тоглох/ г.м

Юуг үнэлэх вэ?	Ямар шалгуураар үнэлэх вэ?
Өөрсдийн болон бусдын үзэл бодол, бүтээлийн ач холбогдлыг ойлгож үнэлж буй байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг сонирхох, ажиглах, сонсох, ойлгох</li> <li>• Хувь хүний мэдрэмж санаагаа илэрхийлэх, бусадтай хуваалцах</li> <li>• Хөгжмийг үнэлэхэд бусдын үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, шүүмжлэлтэй хандах</li> </ul>
Тогтвортой хөгжил, даяаршил, хөгжлийн асуудлыг бүтээлчээр тайлбарлаж, санал солилцож буй байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжмийн хэрэглээ, сонсох дадлыг өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлж, тогтвортой хөгжлийн зарчмын үндэслэлийг тусгах</li> <li>• Хувь хүний ойлголтоо илэрхийлэхдээ урлагийн хэлийг ашиглан аливаа үйлийг гүйцэтгэх</li> <li>• Өөрсдийн санаа, бүтээлийг ярьж тайлбарлах</li> </ul>
Янз бүрийн ашиг сонирхол, нөхцөл байдлыг харгалзан бие даан асуудлыг шийдвэрлэж, дүгнэлтэд хүрч буй байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн сонгосон хөгжмийн бүтээлийн гол агуулга, үзэл санаа түүний үр нөлөөний талаар үнэлэх</li> <li>• Сонссон хөгжмийн талаарх өөр өөр ойлголтуудыг хүлээн зөвшөөрч, үнэлдэг байх</li> <li>• Бусадтай санаа бодлоо хуваалцах, өөрийн бүтээлээр бахархах, бусдын бүтээлийг хүндэлж байгаагаа илэрхийлэх</li> </ul>

**4.6.3. Суурь боловсролын хөгжмийн хичээл****4.6.3.А. Суурь боловсролын “Хөгжмийн хичээл”-ээр ТХБ-д оруулах хувь нэмэр****Үндэслэл**

Тогтвортой хөгжлийн боловсролын талаарх ойлголт, мэдлэг, чадвар, хандлага нь багшийн зааж байгаа хичээлд тусгалаа олж, хичээлийн сэдэвтэй уялдах хэрэгтэй бөгөөд заах арга барил, агуулгадаа тодорхой өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

Хөгжмийн хичээлийн хувьд юмс үзэгдэл, урлагийн бүтээлийг мэдрэх, ойлгох, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сэтгэн бодох, гоо сайхны мэдрэмжээ бүтээлчээр хөгжүүлэх чадваруудыг эзэмшүүлэхийн зэрэгцээ тэдгээрийг хэрэглээ болгох, урлаг хүний амьдралд ямар ач холбогдолтой болохыг ойлгох, амьдралынхаа туршид урлаг, соёлтой ойр байх хүсэл эрмэлзэлтэй сурагч төлөвшүүлэхийг зорьдог.

Сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлснээр урлаг бол тухайн цаг үеийн шууд илрэл гэдгийг сурагчдад ойлгуулахыг эрхэмлэх бөгөөд тухайн үеийн соёл ба нийгмийн байдлаас улбаалан урлаг янз бүр байдаг, нөгөө талаар урлагийн сонирхол ч хүмүүст харилцан адилгүй болохыг ойлгуулна. Мөн сурагч өөрөө хөгжим зохиох ба сонсох, зурах, туршилт хийх замаар урлагийг ойлгож, урлагийн олон төрлөөс шимтэн сонирхох ба өөрийгөө илэрхийлэх ерөнхий чадварыг бусад хичээлтэй холбон хөгжүүлэх, хамтдаа бүтээснээр хариуцлагатай хандах, шүүмжлэлт сэтгэхүйтэй болох агуулгыг эзэмшинэ.

**Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал**

Тогтвортой хөгжлийн зорилго, хөгжмийн хичээлийн суралцахуйн зорилтын хамаарлыг шинжилж үзэхэд суурь боловсролд танин мэдэхүйн, нийгэмшил сэтгэл хөдлөлийн зорилт илүү сонгогдсон байна. Энэ нь анги ахих тусам сурагчдын танин мэдэхүй болон хийх үйл, чадвартай холбоотой болохыг харуулж байна. Шинжилгээний үр дүнг хүснэгтээр харуулбал:

**ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт**

Ай	Танин мэдэхүйн	Нийгэмшил, сэтгэл хөдлөл	Зан үйл	Нийт
Суралцахуйн зорилтын тоо	1	3	1	5

Суурь боловсролд “Суралцагч боловсролоор дамжуулан илүү тогтвортой, эрх тэгш, энх амгалан дэлхийг цогцлоох боломжтойг ойлгодог болох” зорилтыг сургалтын хөтөлбөрийн “Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах явцдаа өөрсдийн авьяас, туршлагадаа тулгуурлан хувилбар боловсруулах” зорилттой холбохдоо боловсролоор дамжуулан ойлгодог болох - бие даан үзэж сонсох, агуулга, дүрийг харьцуулан судлах, хувилбар боловсруулах үгийг түлхүүр болгож сонгосон болно. Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг гол хэрэглэгдэхүүн болох бөгөөд агуулга, үзэл санаа нь хүмүүсийн ёс зүй, уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлдөг талаар өгүүлдэг болно.





<p>2-урьдчилан тооцоолох цогц чадамж. Б.Мөнхболдын "Шар тэнгисийн тарчлаан" жүжгээр дамжуулан урьдчилан дүрмийг үзүүлж, үзэгчдийг ойлгож, урьдчилан сэтгэлгээг бий болгох, урьдчилан сэтгэлгээг зарчмуудыг хэрэгжүүлэх чадвар зэмших ухраас...</p>	<p>2</p>	<p>Туршлагадаа тулгуурлан хувилбар боловсруулахын тулд орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах, туршлагадаа тулгуурлан илэрхийлэх, шинжилгээнд судалгаа хийж, шинжилгээнд суурилсан төсөл, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх аргуудыг өөрсдийн нөхцөл байдлыг тооцно.</p>	<p>Тогтвортой хөгжлийг хөгжүүлэн мэдлэг, чадвар, үнэт зүйлс чадварыг хөгжүүлэхэд чадвартай байхад чадварыг зүйлс болон зан чанарыг боловсруулж дамжуулан илүү тогтвортой, эрх тэгш, энх тайван дэлхийг бүтээх боломжтойг ойлгодог болоход туршлагын Шар тэнгисийн тарчлаан жүжиг хэлбэртэй болно.</p>	<p>ТХ34.Сэ8.</p>	<p>9. 4.3. Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны дэвхэж үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах туршлагадаа тулгуурлан хувилбар боловсруулах Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг</p>
<p>3- хэм хэмжээний цогц чадамж: өөрийн болон бусдын үйл хөдлөл, үзэгчээр үзэгчдийг ойлгож, эргэцүүлэн бодох, мэдэрч, ойлгох тул.</p>	<p>3</p>	<p>Хөгжмийн үр дүрийг төрөл хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинжлэлт өөрчлөлт, гэдэглэх ухраас 3-р арга зүй, түүнд харгалзах дүрд хувирч тоглох, бас олох хөдлөл, өөрсө мийг эсрэг аргуудыг сонгож болно.</p>	<p>Ш.Өлзийбаярын "Дөрвө" үеийн хөгжмийн дэвхэж үзэж сонсох, агуулга дүрийг харьцуулан судлах туршлагын үзэл баримтлал болон суралцагчдад эрүүл, сайхан амьдралын тухай цогц ойлголтыг бий болгож, үзэгчээр үзэгчдийг ойлгуулахад холбоотой болно.</p>	<p>ТХ33.Сэ6.</p>	<p>9. 01.1. Орчин үеийн хөгжмийн үр дүрийг төрөл, хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинжлэлт өөрчлөлт, гэдэглэх ухраас 3-р арга зүй, түүнд харгалзах дүрд хувирч тоглох, бас олох хөдлөл, өөрсө мийг эсрэг аргуудыг сонгож болно.</p>
<p>1- тогтвортой сэтгэлгээ, өмнөх үзэгчид харгалзан хамтарал ойлгож, хэрхэн уялдаж байдал талаар сэтгэн бодох. 5- хамтран амжилтаах бусдын хэрэгцээ үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож, хүндэтгэх, багараа хамтран өмнөх үзэгчид, асуудлыг шийдвэрлэх тул.</p>	<p>1, 5</p>	<p>Хөгжмийн зохиолчид сонирхон судлах арга барил, өөрсө мийг мэдээлэл цуглуулах, задлан шинжлэл хийж, сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваах арга зүйг 23.3-р арга зүйг сонгож, гэдэглэх аргуудыг сургуулийн нөхцөл, байдлыг тооцож, ойлгож хэрэглэн боловсруулна.</p>	<p>Ган гөнг, цаг агаарын онцгой үзэгдэл гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үлдэлтэй гамшиг дагуулсан аюулд нь, нийгмийн болон эдийн засаг, харилцан аюулгүй хамтран амжилтаах цаг Уурын хамтралтэй тэмцэхэд С.Сансэрэлтэй - "Эх дэлхийгээ аварчлаан" зохиол холбоотой болно.</p>	<p>ТХ313.НС3.</p>	<p>9. 3.1. Хөгжмийн бүтээлийг сонин үзэгчид хамтар зохиолчдын арга барил, бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, задлан шинжлэл хийж, сонсох хөгжмийн урын сан бүрдүүлж, бусадтай санаа бодлоо хуваахана. С.Сансэрэлтэй - "Эх дэлхийгээ аварчлаан"</p>

4.6.3.Б. Суурь боловсролын нэгж хичээлийн жишээ: 9-р анги

**Нэгж хичээлийн сэдэв:** Уур амьсгалын өөрчлөлт /Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг/

**Нэгж хичээлийн зорилго:** Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга, дүрийг харьцуулан судлах явцдаа уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг, урьдчилан сэтгүүлэх арга замыг эргэцүүлэн бодож чаддаг болно.

**Хүрэх үр дүн:** Хөгжмийн зохиолчдын бүтээлийн санаа, үүрэг зориулалт, эрэлт хэрэгцээг мэдэх, ойлгох, түүгээр дамжуулан ирээдүйд болох уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлгож мэдэрх, түүнээс урьдчилан сэтгүүлэх, асуудал дэвшүүлэх, санаагаа илэрхийлэх арга замыг бие даан төлөвлөх, хэрэглэгдэхүүнээ сонгох, бодитойгоор зохиомжлон дүрслэх, мэдрэмж, сэтгэгдлээ бүтээлдээ тусгах;


**Нэгж хичээлээр ТХБ-д хувь нэмэр оруулах үндэслэл**

Уур амьсгалын талаарх ойлголт нь сурагчдын хувьд танил хэдий ч хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн тухай мэдэх нь чухал гэж үзэн суурь боловсролын 9-р ангид "Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга, дүрийг харьцуулан судлах явцдаа өөрсдийн авьяас, туршлагадаа тулгуурлан хувилбар боловсруулах" суралцахуйн зорилт, Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжгийг хэрэглэгдэхүүнээр сонгосон. Энэ нь ТХ-ийн зорилгын хүрээнд ТХ313.НСХ1. Суралцагч экосистемийн хувирал өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлтийн хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг, ёс зүйд үзүүлэх нөлөөллийг тайлбарлаж чаддаг болох, ТХ313.Сэ11. Ёс зүй ба уур амьсгалын өөрчлөлт сэдэвтэй агуулгын хувьд холбогдож байна.

Сонгосон сэдвийн хүрээнд суралцагчид хүрээлэн буй орчны уур амьсгалын өөрчлөлт нь юунаас болж, хэрхэн, өөрчлөгддөг, ямар аюул дагуулж болохыг ойлгож, байгаль хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, зохистой хэрэглээг бий болгохын чухлыг ойлгох, тогтвортой байдлыг дэмжсэн үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

**Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХ-ийн зорилго, сэдэвт харгалзах байдал (матриц 1-ээс)**

<p>ТХ3-ын суралцахуйн зорилт</p>	<p>ТХ304.Сэ08. Тогтвортой хөгжлийг хөгжүүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл</p>
<p>ТХ304.ТМ5. Суралцагч боловсролоор дамжуулан илүү тогтвортой, эрх тэгш, энх амгалан дэлхийг цогцлоох боломжтойг ойлгодог болох</p>	<p>9, 4.3. Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга, дүрийг харьцуулан судлах явцдаа өөрсдийн авьяас, туршлагадаа тулгуурлан хувилбар боловсруулах</p>





**Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗ-ын суралцахуйн зорилт ба сэдэвтэй харгалзуулсан үндэслэл**

ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв	Үндэслэл, тайлбар
4	5	6
ТХ304.ТМ1	ТХ34.Сэ8.	Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс болон зан чанарыг боловсролоор дамжуулан илүү тогтвортой, эрх тэгш, энх тайван дэлхийг бүтээх боломжтойг ойлгодог болоход Б.Мөнхболдын "Шар тэнгисийн тарчлаан" жүжиг гол хэрэглэгдэхүүн болно.

**Арга зүйн сонголт:** Шинжилгээ/судалгаа хийх (судалгааны төсөл, кэйс судалгаа, загварчлах)

Орчин үеийн хөгжмийн зохиолчдын тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж сонсох, агуулга, дүрийг харьцуулан судлах учраас 2-р төрлийн арга зүй тохиромжтой. Ингэхдээ задлан шинжилгээ, судалгаа хийх, шинжилгээнд суурилсан төсөл, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх аргуудыг өөрсдийн нөхцөл байдлыг тооцож хийнэ.

Хөгжмийн хичээлээр сурагчид бодит үйл ажиллагаанд оролцох, бүтээлч хэлэлцүүлэг хийх, задлан шинжилгээ хийх, жүжигчилсэн тоглолт зэрэг үйл ажиллагаанд голлон оролцдог тул багшийн арга зүй ч мөн бүтээлч эрэлхийллийн арга барилд чиглэгдэх болно.

**Тогтвортой байдлын цогц чадамж:**

Б.Мөнхболд "Шар тэнгисийн тарчлаан" жүжгийн сэдэв, утга санаа, агуулгатай холбоотой судалгаа шинжилгээ, хэлэлцүүлэг хийх арга зүй нь ТХБ-ын асуудал хөндөн, түүнээс сэргийлэхийн тулд урьдчилан тооцоолох, эрсдэлийг шийдвэрлэх чадварт хувь нэмэр оруулна.

**Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТБ-ын цогц чадамжтай харгалзуулсан үндэслэл**

ТБ-ын цогц чадамж	Хөгжмийн сургалтын хөтөлбөрт тусгасан хүрэх үр дүн
2- урьдчилан тооцоолох цогц чадамж: хөгжмийн зохиолчдын бүтээлээр дамжуулан ирээдүйд болох уур амьсгалын өөрчлөлт-ийн талаар ойлгож мэдрэх, түүнээс урьдчилан сэргийлэх аргаас ярилцах тул,	Тайзны хөгжмийн бүтээлүүдээс бие даан үзэж, үзэсгэлэн, интернетээс судалгаа хийх. Урлагийн бүтээлийн төрөл хэлбэр, хэв маягийн талаар эргэцүүлэн бодох, асуудал дэвшүүлэх Урлагийн илэрхийллийн арга, хэрэглэгдэхүүн, бүтээлийн санаа, үүрэг зориулалт, эрэлт хэрэгцээг мэдэх, ойлгох; Бүтээлийн онцлог, ач холбогдол, үр нөлөөг илрүүлэх асуулт асуух, асуудал дэвшүүлэх; Санаагаа илэрхийлэх арга замыг бие даан төлөвлөх, хэрэглэгдэхүүнээ сонгох, олсон санаагаа бодитойгоор зохиомжлон дүрслэх, мэдрэмж, сэтгэгдлээ бүтээлдээ тусгах; Бүтээлийн хэв маяг, төрөл, илэрхийлэх аргуудыг харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх;

**Нэгж хичээлийн төлөвлөлт**

**Судлах цаг: 2 цаг -80 мин**

Хөгжим сонсох үйл ажиллагаагаар дамжуулан аливаа юмс, үзэгдэлд өөрийн байр сууринаас болон шинжлэх ухааны үүднээс хандаж шүүн тунгаах, үнэлэлт, дүгнэлт өгөх чадварыг хөгжүүлэх боломжтой. Жишээ нь, сурагчид хөгжмийн хичээлээр Б.Дамдинсүрэнгийн "Хэнтийн өндөр ууланд" хийлийн гоцлол, Л.Мөрдоржийн "Хаврын шувууд ирлээ" ёочингийн гоцлол, С.Сансаргэрэлтэхийн "Эх дэлхийгээ аварцаага" симфони уран сэтгэмж гэх зэрэг байгалийн сэдэвтэй олон бүтээлийг сонсдог. Өнөөдөр байгаль, экологийн тэнцвэр алдагдаж, булаг шанд, гол мөрөн ширгэж, усны хомсдол бий болж, байгаль, ой модоо сүйтгэж, зүй бусаар харьцаж байгаа дүр зураг олон бий. Тэгвэл урлагийн бүтээлээр дамжуулан байгальтай хэрхэн харьцах, байгаль эх дэлхийгээ хайрлах, хамгаалахад бидний оролцоо гэх зэргээр асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх арга зам болон хүний зүй бус үйлдэлд үнэлэлт, дүгнэлт өгөх зэргээр аливаа асуудалд хандах бодит чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй.

**Ээлжит хичээл 1**

**Алхам 1:** Сурагчдыг 3-4 бүлэгт хуваана. Бүлэг тус бүр "Эх дэлхий, эх орны минь ирээдүй - Бидний оролцоо" сэдвээр харилцан ярилцаад, түүнд хэрхэн оролцох, юу хийх хэрэгтэй талаар ярилцана.

**Алхам 2:** Ярилцсаны дараа бүлэг дотроосоо хамгийн тодорхой, бүгдээрээ хүлээн зөвшөөрч байгаа 3 сэдвийг сонгон цаасан дээр бичнэ.

**Алхам 3:** Эдгээрээс биелэх найдвартай гэж үзэж байгаа 1-ийг сонгон авч, бусад бүлгүүдэд танилцуулж яагаад сонгосон шалтгаанаа тайлбарлана.

**Алхам 4:** Бүх сурагчдыг Б.Галаарид, Б.Мөнхболд нарын "Шар тэнгисийн тарчлаан" дуулалт жүжгийн бичлэгийг анхааралтай үзэхийг зөвлөнө.

**Алхам 5:** Бичлэгийг үзсэний дараа хичээлийг асуултаар хөтлөх аргаар явуулна. Энэ нь асуултаар хөтлөн сурагчдыг бодох, эргэцүүлэх, бүтээлчээр эрэл хайгуул хийх аргад сургахыг эрмэлзэж байгаа билээ. Иймээс багш та сурагчдад тавих асуултаа боловсруулахдаа хариултыг бус юунд сургах вэ? гэдэг зорилгодоо чиглэсэн эсэхэд анхаараарай.

**Асуулт:**

- Тухайн хөгжмийн зохиолын агуулга бидний амьдрал дээрх ямар алдаа дутагдлыг сануулж, дохио сургамж өгч байна вэ?
- Хөгжмийн зохиолч энэ бүтээлээрээ сонсогчдод юу хэлэхийг хүссэн бэ?
- Хөгжмийн зохиолчийн энэхүү бүтээлийн ач холбогдлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгнө үү?
- Оросын суут хөгжмийн зохиолч П.И.Чайковский "Хэлэх юм надад хэзээд байдаг болохоор хөгжмөөр би ярьдаг" гэж хэлсэн байдаг. Энэ үгийн талаар өөрийнхөө санаа бодлыг илэрхийлнэ үү?
- Хөгжмийн уран бүтээлийн үүрэг, зорилго чухам хэнд, юунд чиглэдэг гэж бодож байна вэ?
- Бид байгаль орчинтойгоо хэрхэн харьцах ёстой вэ? Бид одоо юу хийх хэрэгтэй вэ? зэрэг асуултуудыг дараалуулан тавьж ярилцана.

Алхам 6: Ярилцлагын үр дүн, явцаас шалтгаалан хөгжмийг ярилцлагын дундуур 1-2 удаа давтан сонсоно. Ингэхдээ тохирох оновчтой хэсгийг сонгон хэсэгчилж, сонгож болно.

### Ээлжит хичээл 2

**Алхам 1:** Хөгжмийн зохиолч жүжгийн гол дүрүүдийг ялгахын тулд дөрвөн өөр хөгжмийн хэв маягийг сонгосон байна. Хөгжмөө анхааралтай сонсоод, дүрүүдийн дуулалтын хэв маягийн ялгааг тодорхойлоорой. (жааз, ардын, сонгодог, поп гэх мэт)



**Алхам 2:** Агуулга, дүр, хүний ёс бус үйл ажиллагаа байгаль эх дэлхийд ямар их хор хөнөөл авчирч байгаа болон түүний нөлөө хүмүүст өөрсдөд нь хэрхэн тусч болохыг харуулах, монгол байгаль ахуйд гарч буй бодит өөрчлөлтийг өөрсдийн амьдрал үйл ажиллагааны жишээн дээр ярилцлага хийнэ.

Асуулт:

- Чиний хөгжмөөс сонсож бүтээсэн дүр, харилцан ярилцаж ойлгосон санаа сэдвийг хөгжмийн ямар зэмсгүүдээр илэрхийлсэн байна вэ?
- Яагаад монгол үндэсний болон орчин үеийн хөгжмийн зэмсгийг хослуулан хэрэглэсэн гэж бодож байна вэ?
- Илэрхийллийн ямар аргуудыг ашигласан байна вэ?

**Алхам 3:** Б.Мөнхболдын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн “Тахилгын дуу”-г С.Сансаргэрэлтэхийн “Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмжтэй харьцуулан ижил болон ялгаатай талуудыг тодорхойлох. Ингэхдээ бүтээлүүдийн утга агуулга, хөгжмийн зохиолчийн хэлэх гэсэн санаа юу байв?

- Хөгжмийн зохиолын төрөл зүйл;
- Илэрхийллийн арга, хэлбэр;
- Уламжлал, шинэчлэл;
- Үзэгч сонсогчдын хэрэглээ;
- Зохиолын үүрэг, ач холбогдолд голлон анхаарах хэрэгтэй.




### Тахилгын дуу

Хэрэглэгдэхүүн: Байгаль экологийн тэнцвэр алдагдсанаас үүссэн сэтгэл эмзэглэм дүр зургууд бүхий үзүүлэнгүүд, эх бичвэр, (баримтат мэдээ мэдээлэл, тоон үзүүлэлт ч г.м.)



Б.Мөнхболд нарын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн видео бичлэг, сурах бичиг



### Үнэлэх стратеги, арга, хэлбэр

Хичээл бүрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан сурагчдын хөгжлийн үе шат бүрт ажиглалт хийх, сурагчидтай харилцах, тэмдэглэл хөтлөх, дасгал ажлын хуудас ажиллуулах, суралцахуйн карт, сурагчдын бүтээл, бие даалт, бичгийн шалгалт, тест, асуулт хариулт, ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээн зэрэг үнэлгээний олон арга, хэрэгслүүдээс тухайн нөхцөлд тохирсон, сурагчдыг бодитоор үнэлэх арга хэрэгслийг сонгон хэрэглэж болно. Бичгийн шалгалт нь үнэлгээний үр дүнтэй аргуудын нэг мөн ч, сурагчдын мэдлэг, чадварыг бүх талаар нь илрүүлж чаддаггүй учраас өөр аргуудыг хослуулан үнэлэх хэрэгтэй.

Тухайн нэгж хичээлийн хүрээнд эзэмшсэн байх эцсийн үр дүнгээр үнэлж, үнэлгээний даалгавар боловсруулан ашиглах нь зүйтэй.

Урлагийн бүтээлийг судлах хүсэл, сонирхол, суралцах чадварын хөгжил	Бүтээлчээр хөгжих чадвар	Гүйцэтгэх чадвар	Урлагийн мэдлэг ойлголт
<ul style="list-style-type: none"> <li>Б.Мөнхболдын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн утга санаа, аялгууны дүрслэлийг өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөөр илэрхийлэх</li> <li>Дууны хэмнэл, хурд, хүчний нөлөөлөл, өнгө аяс, шүлгийн агуулга, өгүүлэмжийг мэдрэж, аянд тохирох илэрхийллийг хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зохиолын хэмнэл, хурд, аялгууг мэдрэх</li> <li>Дууны утга, аялгууны дүрслэл, мэдрэмжид тулгуурлан, өөрийн хувилбарыг боловсруулж, олон янзаар дуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Б.Мөнхболдын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн дууны үг, хэмнэл, хүч, хурдыг бодож дуулах</li> <li>Дууг сонсоод тохирох илэрхийллийг багаар гүйцэтгэх</li> <li>Б.Мөнхболдын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн утга санаа, аялгууны дүрслэлд тохирох илэрхийлэл гаргахын тулд үгийн болон амьсгааны хуваарилалтыг зөв дуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн агуулга, утга санааг ойлгох</li> <li>Б.Мөнхболдын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийн дууны нот бичлэгийг ажиглаж, хөгжмийн зарим тэмдэг, тэмдэглээ, тэдгээрийн үүрэг, онцлогийг мэдэх</li> </ul>

Тухайн хичээлийн болон үнэлгээний зорилт, үнэлэх арга, хэрэглэгдэхүүнтэй нягт холбоотойгоор авч үзнэ. Энэ хичээл дээр дараах ажлын хуудсыг ашиглан сурагчдын мэдээлэлтэй ажиллах чадварыг үнэлж болно.

#### Ажлын хуудас 1

Б.Мөнхболд нарын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжиг	
Дууны шүлгийн илэрхийлж буй утга санаа, өнгө аяс, сэтгэлийн илэрхийлэл	
Хөгжмийн онцлог хэмнэл, хурд, хүч, аялгууны өөрчлөлт	

#### Ажлын хуудас 2

Зохиолын нэр	Өөрийн санал дүгнэлт	Бусад сурагчдын санал дүгнэлт
Б.Мөнхболд нарын “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжиг	1	1
	2	2
	3	3

#### 4.6.4. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн хичээл

##### 4.6.4. А. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн хичээлээр оруулах хувь нэмэр

###### Үндэслэл

Нийгэм, эдийн засаг, техник технологийн өндөр түвшний хөгжилд хүрээд байгаа энэ эрин зуунд хөгжлийг дагасан сөрөг үзэгдлүүд түүнтэй холбоотой дэлхийн улс орнуудад яаралтай шийдвэрлэх олон асуудлууд тулгараад байгаа билээ. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гарц нь ТХ ба ТХБ юм. ТХ ба ТХБ-ын холбоо хамаарлыг 2016 онд хийгдсэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа”-ны тайланд “ТХ бол хүн бүрд хамаатай, газар бүр хэрэгжих учиртай нийгэм бүхэлдээ өөрчлөн шинэчлэгдэх үйл явц, харин ТХБ бол байнгын шинэчлэл бүхий энэхүү үйл явцыг хэрэгжүүлэх арга зам” хэмээн тодорхойлсон байна. Энэ нь боловсролоор дамжин тогтвортой хөгжилд хүрэх ба чанартай боловсрол нь ТХ хэрэгжүүлэх тулгуур хэмээх ойлголттой нийцэж байгаа юм.

БСШУЯ-аас ЕБ-ын сургалт үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагыг 2016 онд боловсруулан гаргасан бөгөөд түүнд “ЕБ-ын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай” гээд сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн үндсэн агуулгыг тодорхойлсон байна.

Бага боловсролын түвшинд дүрслэх урлаг, технологийн хичээл нь нэгдмэл агуулгаар хэрэгжиж байгаа бөгөөд дүрслэх урлаг, технологийн сургалтын хөтөлбөр нь “хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг ажиглах, мэдэрч ойлгох”,<sup>137</sup> илэрхийлэх, үнэлэх чадварыг суралцагчдад олгоход чиглэж байна.

ТХБ-ыг тусгайлсан сургалтын хөтөлбөрөөр бус харин түүнийг боловсролын бүхий л түвшний агуулга, арга зүй, хичээл, үйл ажиллагааны үе шат, үйлийн алхам бүрд хэрэгжүүлснээр хангагдах бүрэн боломжтой юм. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн агуулга, хичээл, үйл ажиллагаанд ТХ-ийн “Эрүүл мэнд ба сайн сайхан байдал”, “Зохиистой ажил ба эдийн засаг”, “Тогтвортой хот суурин, оршин суугчид”, “Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл”, “Газар дээрх амьдрал” гэсэн зорилгуудыг интеграцчилах замаар хэрэгжүүлэх боломж байна.

##### Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал

ТХ-ийн ойлголт, үзэл санааг хичээл, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх боломжийг авч үзэх үүднээс бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сургалтын цөм хөтөлбөрт шинжилгээ хийлээ. Шинжилгээг ТХ-ийн 17 зорилгын суралцахуйн зорилт, сэдвийг гол шалгуур болгон түүнд хамаарах суралцахуйн зорилтыг сонгон авсан. (Дараах хүснэгтээс харна уу)

## ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт

Тогтвортой хөгжлийн зорилго	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт
ТХ303. Эрүүл мэнд ба сайн сайхан байдал	5, 01. 14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх
ТХ308. Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт	4, 01.14. Ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох
ТХ311. Тогтвортой хот суурин, оршин суугчид	4, 03.4. Монголын болон гадаадын уран зургаас мэдэх, таних, унших
ТХ312. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл	3, 2.4. Бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал багаж хэрэгсэл сонгох, ашиглах 4, 02. 15. Хаягдал материал ашиглан бүтээл хийх
ТХ315. Газар дээрх амьдрал	3, 01.9. Байгалийн материалыг баримлын шавраар холбох аргаар биет тоглоом хийх

Суралцахуйн зорилтуудыг сонгон авахдаа ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэв болон суралцахуйн зорилтын бодит холбоо хамаарал, ерөнхий зүй тогтол зэргийг харгалзан үзсэн. Сонгон авсан суралцахуйн зорилт болон ТХЗ-ын танин мэдэхүйн, нийгэмшил сэтгэл хөдлөл, зан үйлийн айн хамаарлыг хүснэгтээр харуулав.

## ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилтын тоо

Ай	Танин мэдэхүй	Нийгэмшил, сэтгэл хөдлөл	Зан төлөв
Суралцахуйн зорилтын тоо	2	2	2

Интеграцчилах боломжтой гэж сонгон авсан суралцахуйн зорилтууд нь танин мэдэхүй ай (2), нийгэмшил, сэтгэл хөдлөл ай (2), зан үйл ай (2) харьцангуй тэнцвэртэй байгаа бөгөөд зөвхөн эдгээр суралцахуйн зорилтуудын хүрээнд л тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжинэ. Харин бусад суралцахуйн зорилтуудын хүрээнд ТХБ-ыг хэрэгжүүлэх боломжгүй гэж шууд утгаар ойлгож болохгүй. Учир нь сургалтын цөм хөтөлбөрт ижил томъёологдсон суралцахуйн зорилтууд хэд хэд байна. Энэ нь тухайн судлагдахууны онцлог, бүтээл хийх арга технологи, хэрэглэх багаж, материал, хэрэглэгдэхүүнээс хамааран агуулгын өргөсөл, гүнзгийрэлтэй холбоотой бөгөөд тэдгээр суралцахуйн зорилтуудыг сургалтын хөтөлбөрийн зөвлөмж, сурах бичигт илүү тодруулж өгсөн байна. Үүнтэй холбоотой ТХЗ-ын нэг суралцахуйн зорилт, нэг сэдэвт хамаарах хэд, хэдэн суралцахуйн зорилт гарч ирсэн учир нэгийг нь төлөөлүүлэн сонгон авсан. Иймд багш нар ижил томъёологдсон судлагдахууны суралцахуйн зорилтуудын хүрээнд ТХЗ-ын суралцахуйн зорилт болон сэдвийн хамаарлыг авч үзэн агуулгыг хэрэгжүүлнэ.

## Анхаарах зүйл:

Монголын болон гадаадын уран зураачдын уран зураг унших гэсэн суралцахуйн зорилтын хүрээнд интеграцыг хэрэгжүүлэхдээ багш ТХ-ийн суралцахуйн зорилт, агуулгад нийцүүлэн уран бүтээлийн сонголтыг хийх нь нээлттэй юм. Тухайлбал, Монголчуудын ахуй амьдралын хэв маяг, түүх, соёлын өв уламжлалыг дүрсэлсэн болон тогтвортой хөгжлийн асуудлыг хөндсөн уран бүтээлчдийн уран бүтээлүүдийг сонгон авч хичээл, үйл ажиллагаагаа төлөвлөх хэрэгтэй. Сурах бичигт тусгасан сэдэв, агуулга, уран бүтээл нь ТХ-ийн зорилгод нийцүүлэн интеграцчилах боломжтой

хувилбарыг багтаан өгсөн ба илүү сайн хувилбарыг сонгох үүднээс уран зураачдын бүтээлүүдээс судалж, сонгон авч болно. (Жич: Аливаа суурьшлын бүс нутаг, түүний өөрчлөлтийн түүхийг авч үзэх боломжтой зураг бүтээл гэх мэт).

## Суралцахуйн зорилт, агуулга, аргазүйн интерагцын тодорхойлогдсон байдал

Арга зүйг сонгохдоо суралцахуйн зорилт, тогтвортой хөгжлийн зорилт, сэдвийн хамаарал болон тухайн насны суралцагчийн сонирхол хэрэгцээ, онцлогийг харгалзсан. Агуулга, арга зүй хоёр нь салшгүй холбоотой. Агуулгыг эзэмшүүлэх технологи нь арга зүй буюу арга юм. “Агуулга нь тодорхой бөгөөд оновчтой, арга нь төгөлдөр бөгөөд яруу байх ёстой”<sup>138</sup> гэж тодорхойлсон байна. Арга бүр өөр өөрийн онцлогтой бөгөөд зорилго чиглэлтэй эрэмбэлэгдсэн үйлүүд юм. Судлагдахууны суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх энэхүү арга зүйг сонгохдоо агуулга, арга зүйн шүтэлцээ болон үйл ажиллагааны үе шат, үйлийн алхам бүрд ТБ-ын цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах байдлыг харгалзан үзсэн. Бага боловсролын дүрслэх урлаг, технологийн сургалтын цөм хөтөлбөрийн агуулга, арга зүй бүтээлч эрэлхийллийн арга барил эзэмшүүлэхэд чиглэж байгаа нь дараах санал болгож буй арга зүйг хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх арга зүйг сонгосон байдлыг хүснэгтээр харуулав.

## Арга зүйг сонголт ба тоо

Аргууд			
Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох	Шинжилгээ/ судалгаа хийх	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх	Алсын хараатай болох
1	2	3	

Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга, 1 (видео үзэх), Шинжилгээ/судалгаа хийх арга, 2 (шинжилгээнд суурилсан төсөл, туршилт хийх), Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга, 3 (хэлэлцүүлэг, экскурс) байгаа нь тогтолцоот сэтгэлгээний, хамтран ажиллах, өөрийгөө таньж мэдэх чадамжууд болон асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна.

**Зөвлөмж:** Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргуудаас хэлэлцүүлгийн аргыг сонгосон 2 удаагийн тохиолдол байна. Хэлэлцүүлгийн арга нь суралцагчийн оролцоог хангах арга хэрэгсэл бөгөөд багш үр дүнтэй өрнөж буй эсэхийг анхаарах, хэлэлцүүлэгт өнгөц хандахаас сэргийлэх нь чухал тул хэлэлцүүлгийг урьдчилан бодож, нарийн төлөвлөх нь зүйтэй.



Хүснэгт 4.6.12. Суралцахуйн зорилт арга зүй, цогц чадамжийн интегראц (Бага боловсрол: Дүрслэх урлаг, технологий)

1	2	3	4	5	6	7			8	9	10
						Бодит үйл ажиллагаанд оролцох (компания)	Шийжигдсэн судалгаа хийх (судалгаа)	Бүтээгч, шүүмжлэгчтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ...)			
Бүлэг сэдэв/ Агуулгын хүрээ	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	1 2 3 4 5	ТХ3-ын суралцахуйн зорилт	ТХ3-ын сэдэв	Үндэслэл, тайлбар	Бодит үйл ажиллагаанд оролцох (компания)	Шийжигдсэн судалгаа хийх (судалгаа)	Бүтээгч, шүүмжлэгчтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ...)	Алын сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн үйлдвэрлэх, сурах бичиг, бусад	Код	Үндэслэл, тайлбар
5. Урлагийн хэл	5. 01. 14. Энгийн орд найраглалтай зууш бэлтгэх	✓	ТХ303.371	ТХ303.С909	Суралцагч зууш бэлтгэхдээ амин дэмээр багаар эргүүл хоол хүнсний талаарх ойлголтоо нэмэгдүүлэх ба зөв хооллолтой холбоотой эргүүл амьдралын зам үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэхэд дэмжих нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	✓	✓	✓	Эргүүл мэндийг дэмжих, өөрчлөөс сэрүүлэх стратегийн талаарх суралтыг зохион байгуулах, эргүүл хоол хүнс бэлтгэх, учир 2 дугаар арга зүйг сонгосон.	1,5,6	1-системийн сэтгэлгээ: Эргүүл хоол хүнс бэлтгэх үйлдвэрийн харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох учир. 5-хамтран ажиллах: Бүсдэг ойлгох, мэдрэмжтэй хандах, хамтран суралцах учир... сэтгэлгээ, даллага туршлага өөрийн үнэлэмж, ойлголтоо илэрхийлэх учир...
4. Урлагийн хэл	4. 01. 14. Ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох	✓	ТХ308.НСХ4	ТХ308.НСХ4	Суралцагч ажил мэргэжлийн талаарх ойлголттой болох нь хүний сайн сайхан байдал, эдийн засагт оруулах хувь нэмэр гэсэн санааг үйлдэж харгалзах ажил хөдөлмөртэй холбоотой харгалцаа, үнэт зүйлсээ илрүүлэн тодруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	✓	✓	✓	Өөрийн гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжлийн талаарх туршлагын түүхэн замналыг талаар тэмдэглэл хөтөлж, зуралгал хийх, хэлэлцүүлэх учир 3 дугаар арга зүйг сонгосон.	6	6-шүүмжлэлт сэтгэлгээ: Ажил мэргэжлийн харгалцаа, үнэт зүйлсийг илрүүлэхтэй холбоотой асуудал дэвшүүлж буй учир ...
5. Гоо сайхны интэрхийлэл	4. 02.15. Хаягдал материал ашиглан бүтээл хийх	✓	ТХ312.371	ТХ312.С907	Хаягдал материал ашиглах нь хог хаягдал дахин боловсруулах, дахин ашиглах гэсэн санааг шууд холбогдох ба харгалзан холбоотой үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадвар хувь нэмэр оруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	✓	✓	✓	Хог хаягдал дахин боловсруулах, дахин ашиглах талаар шийжиглэгд, хэрэгжүүлэх, судалгаа учир 2 дугаар арга зүйг сонгосон.	1,7	1-системийн сэтгэлгээ: Аливаа зүйлсийг дахин ашиглах үйлдвэрийн таныг мэдэх, ойлгох нийлмэл тогтолцоог задлан шинжлэх учир... 7-Өөрийгөө таныг мэдэх. Багаараа хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, өөрийн оролцоог эргэцүүлэх учир...

5. Соёлын үнэт зүйл	5. 03.5. Монголын болон гадаадын уран зураачдын уран эргүүл үнших	✓	ТХ311.ТМ3	ТХ311.С905	Монголын болон гадаадын уран зураачдын уран эргүүл үнших нь сурийн амьдралын хөгжлийн түүхэн замналыг үндэслэлтэй хандахад дэмжих болохын зэрэгцээ амьд байгаль хүний суурьшилтай холбоотойгоор өөрчлөгдөн буй талаар асуудал дэвшүүлэн хэлэлцэх, бүтээгчээр илэрхийлэх зэрэг нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	✓	✓	✓	Монголын болон гадаадын уран зураачдын асуудал хөндсөн зурга бүтээлийг ашиглан аливаа суурьшил бүтээгч түүхийг ойлгох, судалж мэдэх учир 3 дугаар арга зүйг сонгосон.	5,6	6-шүүмжлэлт сэтгэлгээ: Амьд орон байгаль, хүний суурьшилтай холбоотойгоор өөрчлөгдөн хувирч буй талаарх асуудлыг дэвшүүлж буй учир... 5-хамтран ажиллах: Хэн нэгний мэдрэмж, хүсэл зорилтыг авч үзэх, хүндэтгэх
3. Гоо сайхны интэрхийлэл	3. 02.4. Бүтээлийн онцлог шавардлагад материал багаж ашиглах	✓	ТХ312.ТМ4	ТХ312.С902	Материал, багаж хэрэгсэл сонгох, ашиглах нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба харгалзан ТҮХ, хэв маягтай холбоотойн зэрэгцээ тогтвортой үйлдвэрлэл ба харгалзан стратегийн практик туршлагыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно. Энэ нь суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	✓	✓	✓	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба харгалзан үнэт зүйлсийг ойлгох мэдэхд нь тулгах зорилгоор болно хэмжээний кино, видео үзүүлэх учир 1 дүгээр арга зүйг сонгосон.	1	1-системийн сэтгэлгээ: Бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба харгалзан хэв загварын харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох учир...
3. Гоо сайхны интэрхийлэл	3. 01.9. Байгалийн шавар үндсэн (шар, чулуу, хуварч унсан мөчир, бордоо) гэх бодотой гэх мэт) баримлын шавар холбох аргаар шавар төлбөр бүтээх	✓	ТХ315.НСХ3	ТХ315.С908	Суралцагч байгалийн хаягдал материалар биег тогтоом бүтээхдээ орон нутгийнхаа байгаль орчинтой харилцаж хүмүүний бус аж амьдралын талаарх ойлголттой болох ба бусадтайгаа хуваагдахдаа хүмүүс амьд байгалийн нэг хэсэг болохыг ойлгож ухаарах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	✓	✓	✓	Байгалийн хаягдал материалыг (унсан наг, боргоцой, мөчир гэх мэт) баримлын шавар болгох зорилгоор болно. Энэ зорилгоор ажиллахад амьдралын талаарх мэдэх, ойлгох зорилгоор болно. Энэ нь суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	1,7	1-тогтолцоот сэтгэлгээ: Орон нутгийнхаа байгаль орчинтой харилцаж хүн ба байгалийн харилцан хамаарал, хүмүүний бус амьдралын талаарх мэдэх, ойлгох үйлдвэрийн талаарх мэдэх, ойлгох учир... 7-Орон нутгийнхаа байгаль орчинтой харилцах, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэх



## 4.6.4. Б. Нэгж хичээлийн жишээ: 5 дугаар анги

**Нэгж хичээлийн сэдэв:** Эрүүл зөв хооллолт ба өглөөний зууш

**Нэгж хичээлийн зорилго:** Эрүүл зөв хооллолт болон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарын талаар судалж өглөөний хоол бэлтгэж сурна.

**Хүлээгдэж буй үр дүн:** Эрүүл хоол хүнсний талаарх болон хүнсний бүтээгдэхүүний харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох, эрүүл хоол хүнс бэлтгэхэд хамтран суралцах, туршлагаа хуваалцах, өөрийн ойлголтоо илэрхийлдэг болно.

**Нэгж хичээлээр ТХБ-д хувь нэмэр оруулах үндэслэл:**

5 дугаар ангийн “Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх” гэсэн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын хүрээнд “Эрүүл зөв хооллолт ба өглөөний зууш” нэгж хичээлийн сэдвийг сонгон авсан ба энэхүү нэгж хичээлийн агуулга ТХ-ийн “Эрүүл мэнд ба сайн сайхан байдал” гэсэн зорилтын суралцахуйн зорилт, сэдэвтэй шууд холбогдох ба шинжилгээ/ судалгаа хийх арга зүйн шийдэл нь ТБ-ын цогц чадамж эзэмшихэд хувь нэмэр оруулна.

Дүрслэх урлаг, технологийн цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт ТХ3-ын суралцахуйн зорилт, сэдэвт харгалзах байдлыг дараах хүснэгтэд харуулав. (Матриц 2-оос)

Суралцахуйн зорилт ТХ3-ын суралцахуйн зорилт, сэдэв харгалзах байдал

	<p>ТХ303.Сэ09. Илүүдэл жин ба таргалалт хөдөлгөөний дутагдал, эрүүл бус хоол хүнс</p>
<p>ТХ303.3Y1. Суралцагч эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болох</p>	<p>5, 01. 14. Энгийн орц найрлагатай зууш бэлтгэх Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт</p>

Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХ3-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэлийг дараах хүснэгтэд авч үзэв. (Матриц 2-оос, багана 4, 5, 6)

ТХ3-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэл

Learning Objectives for TX3s	Topics for TX3s	Үндэслэл, тайлбар
4	5	6
ТХ303.3Y1	ТХ303.Сэ09	Суралцагч зууш бэлтгэхдээ зөв хооллолт болон эрүүл хоол хүнсний талаарх ойлголтоо нэмэгдүүлэх ба зөв хооллолтой холбоотой эрүүл амьдралын зан үйлийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэхэд дэмжих нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.

“Өглөөний хөнгөн зууш бэлтгэх” нэгж хичээл нь суралцагчийн эрүүл хоол хүнс, хооллолтой холбоотой ойлголтыг нэмэгдүүлэх (хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг судлах, өглөөний ундны илчлэгийн хэмжээг тодорхойлох, эрүүл хооллолтын ач холбогдлыг танин мэдэх гэх мэт), тухайн мэдлэг, ойлголтоо ашиглан туршилт хийх (өглөөний унд бэлтгэх, турших) эрүүл хооллолтын ач холбогдлыг хэлэлцэх өдөр тутмын амьдралдаа хэвшүүлдэг болоход хувь нэмэр оруулна. Энэ нь ТХБ-той холбогдох тал болно.

**Арга зүйн сонголт:**

Шинжилгээ/ судалгаа, туршилт хийх) (Матриц 2-оос, багана 8-ТХБ арга зүйн сонголт) ТХБ-ын арга зүйн сонголт

Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж тайлбар

Эрүүл мэндийг дэмжиж, өвчнөөс сэргийлэх стратегийн талаар сургалтыг зохион байгуулах, эрүүл хоол хүнс бэлтгэх учир 2 дугаар арга зүйг сонгосон.

**ТБ-ын цогц чадамж:**

Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж: Эрүүл хоол хүнс бэлтгэхтэй холбоотой хүнсний бүтээгдэхүүний харилцан хамаарлыг танин мэдэх, ойлгох

**Хамтран ажиллах цогц чадамж:** Бусдыг ойлгох, мэдрэмжтэй хандах, хамтран суралцах.

**Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж:** шүүмжлэлт сэтгэлгээ: дадлага туршлага, өөрийн үнэлэмж, ойлголтоо илэрхийлэх (Матриц 2-оос, багана 10)

Эрүүл хоол хүнс бэлтгэх хүрээнд эрүүл хооллолт, илчлэгийн талаар судлах, туршилтын ажил хийх арга зүй нь тогтолцоот, шүүмжлэлт сэтгэлгээний болон хамтран ажиллах чадамжуудад хувь нэмэр оруулна.

**Нэгж хичээлийн төлөвлөлт**

Судлах цаг: 2 цаг - 80 мин

Сургалтын зохион байгуулалтын хэлбэр: Хэсгээр (Суралцагчдыг 5-6-аар нь баг болгон зохион байгуулна).

**Ээлжит хичээл 1.** Эрүүл зөв хооллолт болон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг судлах өглөөний зуушны орц найрлагыг тодорхойлох

**Алхам 1.** Багш хичээлийн эхэнд нийт суралцагчдаас “Та нар өглөөний цайгаа тогтмол уудаг уу?” гэсэн асуулт тавьж хариултыг авна. (Асуултын хариултыг сурагчдыг гар өргөх байдлаар авч болно. Тогтмол уудаг, заримдаа гэх мэт).

Багуудад дараах чиглэлээр асуултыг дэлгэрүүлэн тавьж баг тус бүрээс 1 хариултыг авна. Асуулт асуухаас өмнө багш самбарт дараах хүснэгтийг зурж бэлтгэсэн байна. Хүснэгтийн “мэдээлэлтэй танилцахаас өмнө” гэсэн баганад баг тус бүрээс авсан асуултын хариултыг багш бичиж тэмдэглэнэ. Асуулт:

- Өглөөний цайг тогтмол уухын ач холбогдол юу вэ?
- Эрүүл зөв хооллолтын талаар юу мэддэг вэ?

**Асуулт 1. Өглөөний цайг тогтмол уухын ач холбогдол юу вэ?**

Багууд	Мэдээлэлтэй танилцахаас өмнө	Мэдээллийн танилцсаны дараа ойлгосон зүйл
1-р баг		
2-р баг		
.....		

**Асуулт 2. Эрүүл зөв хооллолтын талаар юу мэдэх вэ?**

Багууд	Мэдээлэлтэй танилцахаас өмнө	Мэдээллийн танилцсаны дараа ойлгосон зүйл
1-р баг		
2-р баг		
.....		

**Алхам 2.** Багш дараах мэдээллийн нийт суралцагчдад ойлгомжтойгоор уншиж өгнө. Багшийг мэдээлэл унших явцад багууд ойлгосон зүйлээ тэмдэглэнэ. Уншиж дууссаны дараа багаараа ярилцаж дээрх асуултад дахин хариулт өгөхөд бэлтгэнэ.

*Унших материал***Эрүүл зөв хооллолт**

Бага насны хүүхдийн эрүүл саруул байлгах гол нөхцөл нь зөв зохистой хооллолт юм. Хоол тэжээл сайтай хүүхдийн оюун ухааны хөгжил сайн байхын зэрэгцээ амжилттай суралцах нөхцөл нь болдог байна. Зөв зохистой хооллох гэдэг нь хүүхдийг эрүүл, хэвийн өсөж хөгжих хэрэгцээг хангахыг хэлнэ. Эрүүл бус хоолонд чихэр, давс, тос ихтэй хоол ордог байна.

Өглөөний цайг тогтмол ууж хэвших нь эрүүл мэндэд ихээхэн ач тустай. Хүүхдийг өдөрт 4-5 удаа хооллох хэрэгтэй. Хооллох цагийн хуваарийг танилцуулвал:

- Өглөөний цай - 7.30 – 8.30
- Бага үдийн цай- 10.30-11.30 г
- Үдийн хоол – 14.30-15.30
- Оройн хоол – 18.30-19.30

Хүүхдүүд та нар хооллохдоо маш сайнажилж идэх хэрэгтэй. Мөн шингэн зүйлийн дутагдлаас сэргийлэх үүднээс ус сайн уух ба өнгө будагтай жүүс, хийжүүлсэн ундааг хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Багш баг тус бүрд дээрх 2 асуултын дахин тавьж, хүснэгтийн “Мэдээлэлтэй танилцсаны дараа” баганад хариултыг тэмдэглэнэ.

**Алхам 3.** Мэдээлэлтэй танилцахаас өмнөх болон мэдээллийг судалсны дараах тэмдэглэлийг харьцуулан ярилцаж, багштайгаа хамтран дүгнэлт гарна.

**Алхам 4.** Дараах нэмэлт мэдээллийг 2 суралцагчийн дунд нэг байхаар тарааж өгнө. Мэдээллийг суралцагчид хамтран чанга уншина. Багш мэдээлэлтэй холбоотой нэмэлт тайлбарыг суралцагчдад хэлж өгнө.

**Нэмэлт мэдээлэл**

Илчлэг чанар гэдэг нь хоолны шим тэжээлийг тодорхойлдог. Илчлэгийн хэмжих нэгж нь ккал бөгөөд хүний хоол хүнснээс авах илчлэгийн хоногийн хэрэгцээ 2500-2550 ккал байдаг байна.

Хүүхдийг өдөрт 4-5 удаа хооллох ба 1 өдөрт шаардлагатай нийт илчлэгийг дараах байдлаар хуваарилдаг байна.

- Өглөөний хоолонд 20%
- Бага үдийн цайнд 10-15%
- Үдийн хоолонд 30-35%
- Их үдийн цайнд 10%
- Оройн хоол, цайд 20-25%

**Алхам 5.** Багш багуудад дараах даалгаврыг өгнө.

**Даалгавар:** Хүний хоол хүнснээс авах илчлэгийн хоногийн нийт хэрэгцээ 2500 ккал ба өглөөний хоолны илчлэг 20%-ийг эзэлнэ. Өглөөний хоолны илчлэгийн хоногийн хэрэгцээг ккал-оор тооцон олно уу. Тооцон олсон тайлбарыг бичиж тэмдэглээрэй.

Илчлэгийн хоногийн хэрэгцээ	Өглөөний хоолны		Тайлбар
	Илчлэгийн хэрэгцээ / хувь/	Илчлэгийн хэрэгцээ /ккал/	
2500 ккал	20%	?	?

*Даалгаврын гүйцэтгэлийн үр дүн:*

Илчлэгийн хоногийн хэрэгцээ	Өглөөний хоолны	
	Илчлэгийн хэрэгцээ /хувь/	Илчлэгийн хэрэгцээ /ккал/
2500 ккал	20%	500

**Даалгаврын дүгнэлт:** Өглөөний хоолны илчлэгийн хэрэгцээнд илчлэгийн хоногийн хэрэгцээний 20%-ийг эзэлдэг ба энэ нь 500 ккал юм байна.

**Алхам 6.** Баг тус бүрд дараах тараах материалыг өгнө.

**Тараах материал:** Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээнд<sup>139</sup> үндэслэсэн болно.

Чиний зохиосон цэсэд орсон хүнсний бүтээгдэхүүний нэр	Өглөөний хоолонд хэрэглэх хэмжээ (гр ба мл)	Илчлэг (ккал) хэмжээ
Сүү	150 гр	120 ккал
Талх	110 гр	22 ккал
Хиам	50 гр	94 ккал
Хүнсний ногоо	200 гр	14 ккал
Өндөг	1ш	225 ккал
Алим	90 гр	44 ккал

**Алхам 7.** Багш багуудад дараах даалгаврыг өгнө.

**Даалгавар:** Баг тус бүр өөрсдийн бэлтгэх өглөөний хоолны орц, найрлагыг тодорхойлж, цэс зохионо. Цэс зохиохдоо илчлэг тооцох ба өглөөний хоолны илчлэгийн хэмжээ 500 ккал хэтрэхгүйг анхаарах хэрэгтэй.

**Бидний зохиосон өглөөний хоолны цэс:**

Чиний зохиосон цэсэд орсон хүнсний бүтээгдэхүүний нэр	Илчлэг (ккал)хэмжээ
.....	
.....	
Өглөөний хоолны илчлэгийн хэмжээ нийт	500 ккал

**Ээлжит хичээл 2.** Өглөөний хөнгөн зууш хийх, турших

**Бэлтгэл ажил:** Багш тухайн хичээлийг зохион байгуулах ажлын орчныг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүнийг төрөл зүйлээр ангилан, зориулалтын саванд угааж, хэрчиж бэлтгэсэн байна.
- Халуунаар боловсруулах шаардлагатай зарим бүтээгдэхүүнийг чанаж боловсруулсан байна.
- Ил хачиртай талх бэлтгэхэд зориулж талхыг 1см зузаанаар эсвэл хавчмал талх бэлтгэх бол 6 мм-ээс зузаантайгаар цэвэрхэн зүсэн бэлтгэсэн байна.
- Хүүхэд бүрийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн ажиллахад чиглүүлэх, ажлын хувцас (хормогч) өмсгөсөн байх.

**Алхам 1.** Баг тус бүр өөрсдийн зохиосон цэсээр өглөөний хөнгөн зууш бэлтгэнэ.

- Суралцагчид хормогч өмсөж, гараа сайтар угааж, ажиллах орчинтойгоо танилцана.
- Багууд өөрсдийн зохиосон цэс, орц найрлагад орох хүнсний бүтээгдэхүүнийг сонгон авна.
- Өөрсдийн зохиосон орц, найрлагын дагуу өглөөний хөнгөн зууш бэлтгэж дуусгана.

**Алхам 2.** Эрүүл зөв өглөөний хөнгөн зуушны амталгаа хийх, үнэлгээ өгөх  
Багш ширээ засах, зөв хооллох талаар суралцагчдад мэдээлэл өгөх хэрэгтэй.

Нэмэлт мэдээлэл: Хүн өдөрт 4-5 удаа хооллох ёстой бөгөөд өглөө, өдөр, оройн хоол өөр өөрийн онцлогтой байдаг. Хооллож сурах нь соёл юм.

Хооллохдоо сандал дээр цэх суух, хөвгүүд нь охидыг суусны дараа суудлаа эзлэх. Амны алчуураа хэрэглэж дууссаны дараа сул нугалж тавгийн хажууд тавих. Ширээн дээр тохойлдож суух, амандаа хэт их хоол хийж идэх, амандаа хоолтой байхдаа ярих зэрэг нь зохимжгүй үйлдэл юм.

**Алхам 3.** Багууд өөрсдийн цэсээр бэлтгэсэн хөнгөн зуушаа ширээнд байрлуулан, амталгаа хийхэд бэлтгэнэ. (Жич: Бэлтгэсэн зуушаа зүсч, чигчлүүр хатган амталгаа хийхэд бэлтгэсэн байж болно)**Алхам 4.** Баг тус бүр өөрийн бэлтгэсэн өглөөний хоолны талаар танилцуулах (Үүнд: орц найрлага, хүнсний бүтээгдэхүүний илчлэг болон эрүүл зөв хооллолттой холбоотой багийн нэгдсэн саналаа илэрхийлэхэд бэлтгэсэн байна)**Алхам 5.** Бусад багуудын бэлтгэсэн өглөөний хоолонд үнэлгээ өгнө. Үнэлгээг дараах шалгуураар багштайгаа хамтран 1, 3, 5 хүртэлх оноо өгч үнэлнэ.

- Амт шаардлага хангасан эсэх
- Гадаад өнгө үзэмж, харагдах байдал
- Орц найрлагад орсон хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг тооцсон эсэх
- Эрүүл зөв хооллолттой болон эрүүл амьдрал зан үйлтэй холбон үзэл бодлоо илэрхийлж буй байдал
- Баг болон ажиллаж чадсан эсэх

**Хэрэглэгдэхүүн:**

- Сурах бичиг V анги
- “Хоол тэжээлийн гарын авлага” хоол судлалын төв, УБ, 2000,
- Зурагт болон видео үзүүлэн
- Ажлын хуудас, тараах материал, үзүүлэн

**Хүнсний бүтээгдэхүүн:**

- Сүү, цэвэр ус
- Талх
- Чанасан өндөг
- Төрөл бүрийн чанаж боловсруулсан хүнсний ногоо
- Бэлэн боловсруулсан, мах, махан бүтээгдэхүүн
- Жимс жимсгэнэ гэх мэт.

Багш өөрөө судлах нэмэлт материал: “Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г (Эрүүл мэндийн сайдын тушаал сэрүүний болон зуны улирлаар нь тогтоон гаргасан байдаг байна.)

**Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ<sup>140</sup>**

Д/д	Хүнсний бүтээгдэхүүний нэр	Сэрүүний улиралд	
		Хоногт хэрэглэх хэмжээ (гр ба мл)	Илчлэг (ккал)
1	Мах, махан бүтээгдэхүүн	200	374
2	Сүү	150	120
3	Тараг, аарц	200	113
4	Гурил	100	325
5	Гурилан бүтээгдэхүүн	220	452
6	Төрөл бүрийн будаа	78	269
7	Сахар, чихрийн зүйл	23	92
8	Төмс	140	123
9	Хүнсний ногоо	200	28
10	Буурцагт ургамал (вандуй, шош)	90	265
11	Жимс	180	84
12	Өндөг	19	30
13	Ургамлын тос	25	225
Бүгд		1625	2500

#### 4.6.5. Суурь боловсролын дүрслэх урлагийн хичээл

##### 4.6.5. А. Суурь боловсролын дүрслэх урлагийн хичээлээр оруулах хувь нэмэр

###### Үндэслэл

Нийгэм, эдийн засаг, техник технологийн өндөр түвшний хөгжилд хүрээд байгаа энэ эрин зуунд хөгжлийг дагасан сөрөг үзэгдлүүд түүнтэй холбоотой дэлхийн улс орнуудад яаралтай шийдвэрлэх олон асуудлууд тулгараад байгаа билээ. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гарц нь ТХ ба ТХБ юм. ТХ ба ТХБ-ын холбоо хамаарлыг 2016 онд хийгдсэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа”-ны тайланд “ТХ бол хүн бүрд хамаатай, газар бүр хэрэгжих учиртай нийгэм бүхэлдээ өөрчлөн шинэчлэгдэх үйл явц харин ТХБ бол байнгын шинэчлэл бүхий энэхүү үйл явцыг хэрэгжүүлэх арга зам” хэмээн тодорхойлсон байна. Энэ нь боловсролоор дамжин тогтвортой хөгжилд хүрэх ба чанартай боловсрол нь ТХ хэрэгжүүлэх тулгуур хэмээх ойлголттой нийцэж байгаа юм.

ЕБ-ын сургалт, үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагыг БСШУСЯ-наас 2016 онд боловсруулан гаргасан бөгөөд түүнд “ЕБ-ын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм соёлын уялдаа холбоо хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай” гээд сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн үндсэн агуулгыг тодорхойлсон байна.

Суурь боловсролын түвшинд дүрслэх урлагийн хичээл нь бие даасан агуулгаар хэрэгжиж байгаа бөгөөд сургалтын цөм хөтөлбөр нь “хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг ажиглах, мэдэрч ойлгох”<sup>141</sup>, илэрхийлэх, үнэлэх чадварыг суралцагчдад олгоход чиглэж байна. Сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг бүтээлч эрэлхийллийн арга барилд<sup>142</sup> тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгасан байна.

- Мэдрэх хүлээн авах (хүрээлэн буй орчин урлагийн бүтээлийн харж ажиглах, ойлгох, утга өгөх)
- Бүтээх гүйцэтгэх (өөрийн санаагаа дүрслэл ашиглан бүтээх турших, мэдрэмж туршлагаа хуваалцах, санаагаа хөгжүүлэх)
- Ойлгох/ үнэлэх (урлагийн бүтээлийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэлийн холбоо хамаарлыг ухааран ойлгох)

Ертөнц дээр оюун ухаант хүн бий болсныг тодорхойлох хамгийн эртний баримтуудын нэг бол зураг дүрслэл юм. Нөгөөтээгүүр хүн мэдлэг, мэдээллийн 80 гаруй хувийг харах эрхтнээр дамжуулан хүлээн авдаг болохыг нотолсон эх сурвалж, судалгаанууд олон бий. Энэхүү харааны хүртэх чадварыг хөгжүүлэх хичээл нь дүрслэх урлаг юм.

Дүрслэх урлаг хэмээх хичээлийн агуулга, зорилгыг ерөнхий утгаар авч үзвэл байгаль дэлхий, орчин тойрон, амьдралын харагдах үзэгдлүүдийг багтаасан, түүнийг уран сайхнаар төсөөлөн сэтгэх үйлийг дэмжихийн зэрэгцээ гоо сайхны мэдрэмжийг

141 БСШУЯ. (2014). Бага боловсролын цөм хөтөлбөр. УБ. 74.

142 БСШУЯ. (2014). Бага боловсролын цөм хөтөлбөрийн зөвлөмж. Боловсролын хүрээлэн. <http://www.mier.mn/mn>.

суралцагчдад төлөвшүүлэхэд чиглэдэг байна. Дүрслэх урлагаар дамжуулан хүмүүсийн дэлхийг харах үзэл бодлыг эергээр өөрчлөх хандлага сүүлийн үед улам бүр нэмэгдсээр байна. Эдгээрийг дүрслэх урлагийн боловсролын ТХБ-ын үзэл санаа, ойлголтыг хэрэгжүүлэх боломж, холбогдох тал гэж ойлгож байна.

###### Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал

Суурь боловсролын түвшинд дүрслэх урлаг нь бие даасан агуулгаар хэрэгжиж байгаа бөгөөд тус судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрт шинжилгээ хийж ТХ-ийн ойлголт, үзэл санааг хичээл, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх боломжийг авч үзсэн. Шинжилгээг ТХ-ийн 17 зорилгын суралцахуйн зорилт, сэдвийг гол шалгуур болгон түүнд хамаарах суралцахуйн зорилтыг ТХЗ-ын айгаар ялган авч үзсэн. (Дараах хүснэгтээс харна уу)

ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилтын тоо

Ай	Тогтвортой хөгжлийн зорилго	Танин мэдэхүй	Нийгэмшил, сэтгэл хөдлөл	Зан үйл
ТХ304.	Чанартай боловсрол	1	-	-
ТХ311.	Тогтвортой хот суурин, оршин суугчид	1	-	-
ТХ312.	Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл		1	-
ТХ315.	Газар дээрх амьдрал	1	2	-
Нийт		3	3	-

Интеграцчилах боломжтой гэж ялган авсан суралцахуйн зорилтууд нь танин мэдэхүйн (3), нийгэмшил сэтгэл хөдлөлийн (3) айд, ТХ-ийн Чанартай боловсрол (1), Тогтвортой хот суурин, оршин суугчид (1), Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (1), Газар дээрх амьдрал (3) гэсэн зорилгуудад тус тус хамаарч байна. Зөвхөн эдгээр суралцахуйн зорилтын хүрээнд тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлнэ харин бусад суралцахуйн зорилтууд нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх боломжгүй гэж шууд утгаар ойлгож болохгүй. Дүрслэх урлагийг ерөнхий утгаар авч үзвэл хэрэглээний урлаг бөгөөд өдөр тутмын амьдралын гоо зүйг өөртөө багтаадаг. Тухайлбал, уран зургаас эхлээд кино урлаг хүртэл, зураг төслөөс архитектур хүртэл, загвараас интерактив мэдээллийн хэрэгсэл хүртэл, урлагийн үзүүлбэрээс зураглал хүртэлх гэх мэт нүдэнд харагдах бүхий л үзэгдлүүдийг дүрслэх урлаг өөртөө багтаадаг байна. Дүрслэх урлаг нь бидний дэлхийг харах үзэл бодлыг бий болгож, бодит амьдрал дээрх зургийн ач холбогдлыг илүү их онцлох, түүнийг хариуцлагатай ашиглах нь өнөө үед улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь дүрслэх урлагаар дамжуулан ТХ нь хүн бүрд хамаатай гэдгийг ухаарч ойлгуулахад хувь нэмэр оруулах боломж буйг харуулж байна.

###### Анхаарах зүйл:

Дүрслэх урлагийн сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын хүрээнд интеграцыг хэрэгжүүлэхдээ багш ТХЗ-ын суралцахуйн зорилт, агуулгад нийцүүлэн уран бүтээлийн сонголтыг хийх нь нээлттэй юм. Тухайлбал, Монголчуудын ахуй амьдралын хэв маяг, түүх, соёлын өв уламжлалыг дүрсэлсэн болон тогтвортой хөгжлийн асуудлыг хөндсөн уран бүтээлчдийн уран бүтээлүүдийг сонгож авч хичээл, үйл ажиллагаагаа төлөвлөх боломжтой юм. Сүүлийн үед уран бүтээлчид төрөл

бүрийн түвшинд дэлхийн даяарчлалын талаарх цогц асуудлууд болон сэдвүүдийг хөндөж, уран бүтээлээ туурвиж буй жишээ олонтоо тохиолдох болжээ. (улс төрийн, экологийн, урлагийн ач холбогдлын талаарх асуудлууд, нийгэм соёлын, үйлдвэрлэл ба хэрэглээний талаар, соёл урлагийн гэх мэт)

**Суралцахуйн зорилт, агуулга, арга зүйн интеграцын тодорхойлогдсон байдал**  
Арга зүйг сонгохдоо суралцахуйн зорилт, тогтвортой хөгжлийн зорилт, сэдвийн хамаарал болон тухайн насны суралцагчийн сонирхол хэрэгцээ, онцлогийг харгалзан авч үзсэн.

Агуулга, арга зүй хоёр нь салшгүй холбоотой. Агуулгыг эзэмшүүлэх технологи нь арга зүй буюу арга юм. "Агуулга нь тодорхой бөгөөд оновчтой, арга нь төгөлдөр бөгөөд яруу байх ёстой"<sup>143</sup> гэж тодорхойлсон байна. Арга бүр өөр өөрийн онцлогтой бөгөөд зорилго чиглэлтэй эрэмбэлэгдсэн үйлүүд юм. Судлагдахууны суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх энэхүү арга зүйг сонгохдоо агуулга, арга зүйн шүтэлцээ болон үйл ажиллагааны үе шат, үйлийн алхам бүрд ТБ-ын цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах байдлыг харгалзан авч үзсэн. Суурь боловсролын дүрслэх урлагийн сургалтын цөм хөтөлбөрийн агуулга, арга зүй бүтээлч эрэлхийллийн арга барил эзэмшүүлэхэд чиглэж байгаа нь дараах санал болгож буй арга зүйг хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх арга зүйг сонгосон байдлыг хүснэгтээр харуулав.

Арга зүйн сонголт ба тоо

Аргууд			
Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох	Шинжилгээ/ судалгаа хийх	Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх	Алсын хараатай болох
2	2	3	-

Арга зүйн сонголт нь: Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга 2 (тэмдэглэлт өдрийг тэмдэглэх), Шинжилгээ/ судалгаа хийх арга, 2 (шинжилгээнд суурилсан төсөл), Бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан арга, 3 (хэлэлцүүлэг, экскурс) байгаа нь тогтолцоот сэтгэлгээний, хэм хэмжээний, шүүмжлэлт сэтгэлгээний, хамтран ажиллах, өөрийгөө таньж мэдэх нэгдсэн цогц чадамжийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна.

**Зөвлөмж:** Аргыг сонгосон байдлыг авч үзвэл, бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргуудаас хэлэлцүүлгийн аргыг давуу сонгосон (3 удаа) байна. Хэлэлцүүлгийн арга нь суралцагчийн оролцоог хангах арга хэрэгсэл бөгөөд багш үр дүнтэй өрнөж буй эсэхийг анхаарах, хэлэлцүүлэгт өнгөц хандахаас сэргийлэх нь чухал тул хэлэлцүүлгийг урьчилан бодож, төлөвлөх нь зүйтэй. Хэлэлцүүлэг арга нь суралцагчдын өөрийн байр сууриа илэрхийлэх, бусдынхаа ялгаатай үзэл бодлыг сонсох, хүндэтгэлтэй хандах чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ тэдэнд өөдрөг бодол, урам зориг өгөхөд чиглэдэг байх ёстой.

143 Мира, Н. (2006). Суралцах арга барилын технологийн шинэчлэл. УБ, 68.

Хүснэгт 4.6.13. Суралцахуйн зорилт арга зүй, цогц чадамжийн интеграл (Суурь боловсрол: Дүрслэх урлаг, технологи)

Цогц чадамж	Код	Арга зүй	
		ТХБ	Анги
Үндэслэл, тайлбар	10	6-шүүмжлэлт сэтгэлгээ: Амьд онгон байгаль, хүний суурьшилтай холбоотойгоор өөрчлөгдөн хувирч буй талаарх асуудлыг дэвшүүлж буй учир... хамтран ажиглах. Хэн нэгний үзэл зорилгыг авч үзэх, хундатгах.	6-шүүмжлэлт сэтгэлгээ: Эцэс үлдсэн болон өөрийн бодол санаа, ойлголтоо илэрхийлэх, харьцуулах, хэлэлцэх. 7-өөрийгөө таньж мэдэх. Өөрийн бодол санаа, ойлголтоо илэрхийлэх, өөрийн зүгээс хариу өгөх, үзэл зорилгыг авч үзэх.
Арын сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж, тайлбар / суралцахуйн үндэсний зорилт, бусад	9	Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зураг бүтээлийн агуулга, дүрслэлээр дамжуулан аливаа суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.	Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зураг бүтээлийн агуулга, дүрслэлээр дамжуулан аливаа суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.
Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх (хэлэлцүүлэг, ...)	7	Шинжилгээ/судалгаа хийх арга, 2 (шинжилгээнд суурилсан төсөл, ...)	Чанартай боловсрол талаарх олон нийтийн сэдвийг мэдээллийг агуулга, судалгаа, суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.
Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох (Компаньон, ...)	2	Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох	Чанартай боловсрол талаарх олон нийтийн сэдвийг мэдээллийг агуулга, судалгаа, суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.
ТХБ-ын сэтгэл	5	ТХБ-ын сэтгэл	Суралцагч сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зураг бүтээлийн агуулга, дүрслэлээр дамжуулан аливаа суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.
ТХБ-ын сэтгэл	4	ТХБ-ын сэтгэл	Суралцагч сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зураг бүтээлийн агуулга, дүрслэлээр дамжуулан аливаа суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.
Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	2	Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт	8.03.1. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зураг бүтээлийн агуулга, дүрслэлээр дамжуулан аливаа суурьшил бус нутаг, түүний өөрчлөлтийг түүхтэй холбон судалж асуудлыг дэвшүүлэн суулгах. Учир 3 дугаар арга зүйг сонгосон.
Бүтэц сэдэв/ Агуулгын хүрээ	1	Бүтэц сэдэв/ Агуулгын хүрээ	8.03.2. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлтэй танилцах, эрхэлжүүлэх, асуудал дэвшүүлэн хэлэлцэх.



Урлаг бүтээхүй	8.02.16. Ахуйн чөлөөлөгч бүлгийн нэгдсэн төслийн хөгжүүлэлт, чимэглэл хийх	Урлаг бүтээхүй	Суралцагч ахуйн хөгжлийн дахин боловсруулах, дахин үндэстэй ашиглах талаар шинэ санаа гарган хэрэгжүүлснээр өөрийн хэрэглэн дэх тогтвортой практик туршлага хэрэгтэй бусдад таниулан сурталчлахад хувь нэмрээ оруулах ба энэ нь тухайн суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах талаар шинэ санаа гарган хэрэгжүүлэх, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, сурталчлах үүрэг 2 дугаар арга зүйг сонгосон.	1-системийн сэтгэлгээ. Аливаа зүйлийн харилцан хамаарлыг таньж мэдэх, ойлгох нийгмэл тогтолцоог задлан шинжлэх үүрэг. 7-Өөрийгөө таньж мэдэх. Багаараа хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, өөрийн оролцоог эргэцүүлэх учир...
Урлаг бүтээхүй	6.01.8. Амьтны биений бүлгийг сэрхийлжээг дүрсэлж зурах.	Урлаг бүтээхүй	Суралцагч орон нутгийн болон дэлхийн экосистемтэй холбоотой үндсэн экологийг ойлгож, орон нутгийн амьтдын төрөл зүйлийг тодорхойлох, өөр хоорондоо ялгарах онцлог шинж төрлийг дүрсэлж зурахад хувь нэмрээ оруулах ба энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	"Дэлхийн байгаль орчны өдөр"-ийг амьдралын өнгөрүүлэх хүрээнд ойлгож, орон нутгийн амьтдын төрөл зүйлийг тодорхойлох үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийн хамт хүрээлэн буй орчин амьд байгаль, ан амьтдын талаар асуудал хөндсөн сэдэвт зургийн уралдаан оролцох үүрэг 1 дүгээр арга зүйг сонгосон.	1-системийн сэтгэлгээ. Хүн амьтдын хамаарлыг таньж мэдэх, ойлгох учир... 7-Өөрийгөө таньж мэдэх. Дэлхий болон орон нутгийг түүвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэх учир...
Урлаг бүтээхүй	7.02.12. Байгалийг бодит байдлаас харж зурах.	Урлаг бүтээхүй	Суралцагч орон нутгийн байгаль орчингоо харилцаж, байгалийн бодит байдлыг амьдралт хийх явцад хүмүүс амьдралын дагуу өөрсдийн талаар эргэлцүүлэх зорж дүрслэх үүрэг нь хүмүүний бус амьдралыг ойлгоход суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	Байгалийн бодит байдалд ажиглалт хийж зурах, дүрслэх зорилгоор оролцох, цэцэрлэгт хүрээлэнд эхлүүлж аврал хийх үүрэг 3 дугаар арга зүйг сонгосон.	1-тогтлооцот сэтгэлгээ. Орон нутгийнхаа байгаль орчинтой харилцах хүн ба байгалийн харилцааг дагуу өөрсдийн бус амьдралын талаар мэдэх, ойлгох учир... 1,7-Өөрийгөө таньж мэдэх. Орон нутгийнхаа байгаль орчинтой харилцах, өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэх учир...
Урлаг бүтээхүй	8.01.8. Хүн ба амьтны судалбар зурах	Урлаг бүтээхүй	Суралцагч нь хүн ба амьтны судалбар зурахдаа хүмүүс бид байгалиас салагчид бус харин байгалийн нэг хэсэг нь болохыг ухаарч, хүн нийгмийн болон байгалийн харилцааг шинжлэх болох талаар асуудал хөндсөн сэдэвт зургаа оруулах нь энэ суралцахуйн зорилтын ТХБ-той холбогдох тал болно.	Бүлгийн төрөл зүйлийн олон янз байдлыг холбоотой шинжилгээнд суурилсан төсөл боловсруулах үүрэг 2 дугаар арга зүйг сонгосон.	3-Хэм хэмжээний. Хэн нэгний үйл явдал болсон учир хэмжээний харилцааг үнэлэмжийг ойлгох, эргэцүүлэх учир... 7-Өөрийгөө таньж мэдэх. Дэлхий болон орон нутгийг түүвшинд өөрийн үүрэг оролцоог эргэцүүлэх

4.6.5. Б. Нэгж хичээл жишээ: 8 дугаар анги

Нэгж хичээлийн сэдэв: Монголын орчин үеийн уран бүтээлчдийн зураг бүтээлтэй танилцана.

Нэгж хичээлийн зорилго: Зураач Я. Булган “Судар ижий”, зураач С. Заяасайхан “Амьд үлдэгсэд” уран бүтээлийн агуулга, утга санаа, уран дүрлэлээр дамжуулан ТХ-ийн үзэл санаа, ойлголтыг нэмэгдүүлэх, бусдад таниулах, сурталчлахад соёлын үүрэг чухал болохыг ойлгодог болно.

Хүлээгдэж буй үр дүн: Монголын орчин үеийн уран бүтээлч, зураач Я. Булган “Судар ижий”, зураач С. Заяасайхан “Амьд үлдэгсэд” зэрэг уран бүтээлийн агуулга, утга санаа, уран дүрслэлд өөрийн зүгээс үнэлэмж өгөх, уран бүтээлчдийн мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх, тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн байр сууриа илэрхийлнэ.

Нэгж хичээлээр ТХБ-д хувь нэмэр оруулах үндэслэл:

VIII ангийн сургалтын хөтөлбөрийн “Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлтэй танилцах” гэсэн суралцахуйн зорилтын хүрээнд Монголын орчин үеийн уран бүтээлч, зураач Я. Булган “Судар ижий”, зураач С. Заяасайхан “Амьд үлдэгсэд” гэсэн уран бүтээлийг сонгон авч нэгж хичээлийг төлөвлөсөн.

Энэхүү нэгж хичээл, сонгон авсан уран бүтээлийн сэдэв, агуулга нь ТХ-ийн суралцагч нь тогтвортой байдалд хүрэхэд соёл чухал үүрэгтэйг ойлгодог болох гэсэн суралцахуйн зорилттой холбогдохын зэрэгцээ, тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл гэсэн сэдэвт дэмжлэг үзүүлнэ. Мөн тухайн хичээлийн арга зүй нь бүтээлч шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргуудаас хэлэлцүүлгийн аргыг сонгон авч арга зүйн дэглэлт хийсэн нь ТХБ, ТХ-ийн чадамж эзэмшихэд хувь нэмэр оруулна.

Дүрслэх урлаг, технологийн цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт ТХБ-ын суралцахуйн зорилт, сэдэв харгалзах байдлыг хүснэгтээр харуулав. (Матриц 1-ээс)

Суралцахуйн зорилт ТХБ-ын суралцахуйн зорилт, сэдэв харгалзах байдал

	ТХ304.Сэ08. Тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардагдах мэдлэг, чадвар, үнэт зүйлс ба зан үйл
ТХ304.ТМ4. Суралцагч нь тогтвортой байдалд хүрэхэд соёл чухал үүрэгтэйг ойлгодог болох	8.03.2. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлтэй танилцах  Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт

Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэлийг дараах хүснэгтэд авч үзэв. (Матриц 2-оос, багана 4, 5, 6)

## ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэл

ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв	Үндэслэл, тайлбар
4	5	6
ТХ304.ТМ4	ТХ304.Сэ08	Суралцагч монголын орчин үеийн дүрслэх урлагийн төлөөлөгчдийн ТХБ-ын асуудал хөндсөн бүтээлүүдийн сэдэв, утга санаа, агуулгатай танилцаж тогтвортой хөгжлийн мэдлэг, үнэт зүйлс ба зан үйлийн талаарх ойлголтоо нэмэгдүүлэх зэрэгцээ өөрт төрсөн сэтгэгдлээ зураг дүрслэлээр илэрхийлэн зурах, тайлбарлан таниулах, сурталчлах зэрэг нь тогтвортой хөгжилд соёл чухал үүрэгтэйг ойлгоход дэмжлэг болно.

Монголын орчин үеийн уран бүтээлчдийн зураг бүтээлийн харж ажиглах, ойлгох, утга өгөх, өөрийн санаагаа илэрхийлэх, урлагийн бүтээлийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэлийн холбоо хамаарлыг ухааран ойлгодог болоход чиглэнэ.

Монголын орчин үеийн дүрслэх урлагийн төлөөлөгчдийн ТХБ-ын асуудал хөндсөн дүрслэх урлагийн бүтээлийн ач холбогдлыг онцлох, сэдэв, утга санаа, агуулгаар дамжуулан суралцагчдын дэлхийг харах үзэл бодлыг өөрчлөх, тогтвортой хөгжлийн мэдлэг, үнэт зүйлс ба зан үйлийн талаарх ойлголтоо нэмэгдүүлэх, бусдад таниулах, сурталчлахад соёлын үүрэг чухал болохыг ойлгуулах нь ТХБ-той холбогдох тал юм.

**Арга зүйн сонголт:** Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэхүй ба сэтгэлгээ шаардсан аргууд (хэлэлцүүлэг)

ТХ-ын арга зүйн сонголт (Матриц 2-оос, багана 8)

Аргыг сонгосон үндэслэл, хэрэгжүүлэх боломж тайлбар

Орчин үеийн дүрслэх урлагийн төлөөлөгчдийн ТХБ-ын асуудал хөндсөн бүтээлүүдийн сэдэв, утга санаа, агуулгатай холбоотой хэлэлцүүлэг өрнүүлэх учир арга зүй 3-ыг сонгосон.

**Тогтвортой байдлын цогц чадамж:**

Орчин үеийн дүрслэх урлагийн төлөөлөгчдийн ТХБ-ын асуудал хөндсөн бүтээлүүдийн сэдэв, утга санаа, агуулгатай холбоотой хэлэлцүүлэг өрнүүлэх арга зүй нь шүүмжлэлт сэтгэлгээний болон өөрийгөө таньж мэдэх цогц чадамжуудад хувь нэмэр оруулна.

**Цогц чадамжийг тодорхойлсон үндэслэл (Матриц 2-ийн, 10 багана)**

Цогц чадамжид оруулах хувь нэмэр, үндэслэл, тайлбар

**6- шүүмжлэлт сэтгэлгээ:** Тогтсон хэм хэмжээ, дадал туршлагад асуудал дэвшүүлэх, тогтвортой байдлын тухай яриа хэлэлцээрт өөрийн байр суурьтай байх

**7- өөрийгөө таньж мэдэх:** Өөрийн зүгээс үнэлэмж өгөх, хэн нэгний мэдрэмж, хүсэл зорилгыг авч үзэх

## Нэгж хичээлийн төлөвлөлт

**Хугацаа:** 2 цаг - 80 минут

**Сургалтын зохион байгуулалтын хэлбэр:** Суралцагчдыг 8-10-аар нь 4 баг болгоно.

**Ээлжит хичээл 1.**

Бэлтгэл ажил: Багш сургалтад ашиглах зураг уран бүтээлийг үзүүлэн болон тараах материал байдлаар олшруулан бэлтгэсэн байна. (Уран бүтээлийн харагдах байдлыг харгалзан өнгөтөөр хэвлэсэн байх)

**Алхам 1.** Багуудад зургийг тараан өгнө. (Зураг дээр зураач болон зургийн нэр бичигдсэн байх)

1, 3 дугаар багт

2, 4 дүгээр багт

Зураач: Я.Булган  
Зургийн нэр: "Судар ижий"



Зураач: С.Заяасайхан  
Зургийн нэр: "Амьд үлдэгсэд"



**Алхам 2.** Суралцагчдад зураг бүтээлийг харж ажиглах (өөрийн эргэцүүлэл хийх, утга өгөх) хугацаа өгнө. Багш идэвхтэй ажиглалт хийхэд чиглүүлнэ.

**Чиглүүлэх асуулт:** (Багш хэлэлцүүлгийн асуултыг самбарт байршуулсан байна)

- Зураг дээр юу дүрсэлсэн болохыг тоочин нэрлэнэ үү?
- Уран бүтээлийн гол ба туслах дүрийг зургийн хавтгайн аль хэсэгт хэрхэн байрлуулсныг тодорхойлно уу?
- Зохиомжийн ямар аргыг ашигласан байна вэ? зургийн өнгө зохицлыг өөрийн бодлоор тодорхойлон хэлнэ үү?
- Зургийн гол агуулга нь юу вэ? Хэрхэн илэрхийлсэн байна вэ?
- Тухайн зургийн талаарх өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлнэ үү?

Бүтээх буюу санаагаа хөгжүүлэх үе шат:

**Алхам 3.** Чиглүүлэх асуултын дагуу багууд хэлэлцэн хариултыг тэмдэглэн танилцуулахад бэлтгэнэ.

Асуулт	Асуултын хариулт (дэлгэрэнгүй)
Асуулт 1.	
Асуулт 2.	
Асуулт 3.	
Асуулт 4.	
Асуулт 5.	

**Алхам 4.** Багуудын хариултыг сонсоно. Багш 1 уран бүтээл дээр саналаа илэрхийлсэн багуудын ялгаатай талыг тодруулж хэлэх ба багуудад ялгаатай байр сууриа дэлгэрүүлж тайлбарлахыг багийн гишүүдээс хүсэх байдлаар хэлэлцүүлгийг идэвхжүүлнэ. Хэлэлцүүлгийн үеэр багш суралцагчдын хариултыг зөв, буруу гэх мэтээр дүгнэх болон шүүмжлэхгүй. Мөн хэлэлцүүлгийн асуултад багш өөрөө хариулт өгөх ёсгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

**Зөвлөмж:** Багш суралцагчдын оролцоог хангах үүднээс багийн гишүүдийг урьдчилан дугаарласан байх ба хариултыг авахдаа гишүүдийн дугаараас сугалах байдлаар хэлэлцүүлгийг зохион байгуулж болно.

**Алхам 5.** Баг тус бүрийн танилцуулгаас багш хамгийн сонирхолтой хэсгүүдийг самбарт ерөнхийлөн дүгнэж бичнэ. Мөн багш тухайн 2 уран бүтээлийн агуулга утга санааг зураачдын өөрсдийн тайлбартай холбон нэмэлт мэдээллээр өгнө.

Зураач: **Я. Булган**

Зургийн нэр: “Судар ижий”

Энэ бүтээл нь гал улаан, дүрэлзсэн, оргилсон өнгөөр илэрхийлэгдсэн ба зураач маань үүнийг: Миний дотоод сэтгэлийг өнгөөр илэрхийлбэл яг ийм өнгөтэй гэж тайлбарласан байна.



Бүтээлд эмэгтэй хүнээр эх дэлхий байгаль ертөнцийг, хүүхдүүдээр хүн төрөлхтнийг төлөөлүүлэн дүрсэлсэн байна. Зургаас монгол зургийн арга, хэв шинж харагддаг ба байгаль дэлхий хүүхдүүддээ гомдож тунж байгаа ба хүн төрөлхтөн эх дэлхий, оршихуйдаа хэрхэн хандаж буйг талаарх асуудлыг хөнджээ. Байгаль дэлхий зовж цөхөрсөн байгааг энэхүү бүтээлээрээ илэрхийлсэн байна.

**Зөвлөмж:** Суралцагчдад хэлэлцүүлгийн явцад гарсан чухал санааг дэвтэртээ тэмдэглэн авах даалгаврыг өгнө. Энэ нь хэлэлцүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх нөгөө талаар хэлэлцүүлгийн дараа тухайн сэдвээр өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, асуудал дэвшүүлсэн сэдэвт зураг зурах зэрэгт ашиглаж болно.

Зураач: **С.Заяасайхан**

Зургийн нэр: “Амьд үлдэгсэд”

Энэ бүтээл нь У л а а н б а а т а р хотын асуудлыг хөндсөн ба хотын иргэд бид өвөл болохоор цэвэр агаар амьсгалж ч а д а х г ү й байна шүү дээ.



Ерөнхийдөө энэ бүтээлийг харахад маскаар дамжуулж утааны асуудлыг шулуухан илэрхийлсэн мэт боловч уг зурагт өөр далд утга ч бас бий. Хүмүүс бидний байгуулж буй хэт хотжилт, хэт бөөгнөрөл, өндөр хөгжил дэвшил нь эргээд хүн өөрөө амьд, байгалийн орчинд амьдрах боломж, бололцоог хааж буй асуудлыг уран бүтээлээрээ дамжуулан хөндсөн юм.

## Ээлжит хичээл 2.


Алхам 1. Багш хэлэлцүүлгийн 2 хэсэгт орно. Сонгон авсан 2 уран бүтээлийн ижил төстэй ба ялгаатай талыг харьцуулан даалгаврыг багуудад өгнө. (Венийн диаграмм ашиглаарай)

### Венийн диаграмм

"Судар ижий"

А-гийн тухай, Б-гийн тухай

"Амьд үлдэгсэд"



А-гийн онцлог А болон Б-н нийтлэг тал Б-гийн онцлог

**Алхам 2.** Багуудын даалгаврын гүйцэтгэлээ танилцуулна. Багш багуудын тайлбар дээр нэмэлт мэдээлэл авч дууссаны дараа хэлэлцүүлгийн үеэр багууд болон гишүүдээс дэвшигдсэн асуудлууд болон чухал санааг самбарт бичиж дүгнэлт хийнэ.

**Алхам 3.** Хэлэлцүүлгийн явцад хөндөгдсөн сэдэв, агуулгын хүрээнд суралцагчид өөрт төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлнэ.

Сэдэв сонгох (хэлэлцүүлгийн тэмдэглэл, хэлэлцүүлгийн явцад хөндөгдсөн асуудлуудыг эргэцүүлэх, эрэл хайгуул хийх, давтагдсан биш, асуудал дэвшүүлсэн санаа байх)

Эскиз хийх (зурах зургаа урьдчилан төсөөлөх, хэд хэдэн хувилбараар эскиз хийх)

Эх зургаа зурах (Зурах дэвсгэртийн байрлал, зохиомж зөв сонгох (хэвтээ, босоо))

Суралцагчид бүтээлдээ ТХ-ийн талаарх тодорхой байр суурь, асуудлыг дэвшүүлсэн байх нь чухал гэдгийг багш анхааран чиглүүлэх хэрэгтэй.

**Алхам 4.** Суралцагчид бүтээлийн агуулга, утга санаа, шийдлийг танилцуулах (Багш суралцагч бүрийн хийсэн бүтээлийг самбарт байршуулах ба аль болох олон сурагчдын танилцуулгыг сонсох хэрэгтэй)

### Хэрэглэгдэхүүн:

Зураач Я. Булган “Судар ижий”

Зураач С. Заяасайхан “Амьд үлдэгсэд” (<http://www.buro247.mn/culture/art-theatre/>)

зурагт үзүүлэн, тараах материал

### Ажлын хуудас

Зургийн дэвтэр, балын харандаа, усан будаг, гуаш, бийр

Үнэлгээ: Үнэлгээг дараах шалгуураар багштайгаа хамтран үнэлнэ.

Суралцагчдын оролцоог үнэлэх (Оролцоо бага, дунд зэрэг, идэвхтэй оролцсон)

Суралцагчийн хариулт утга төгөлдөр санааг бүрэн илэрхийлсэн эсэх

Хариултыг баримтад тулгуурлан дэлгэрүүлэн тайлбарласан эсэх

Бүтээлийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэлийн холбоо хамаарлыг ухааран ойлгож буй байдал  
ТХБ-ын тодорхой асуудал хөндсөн ухуулга сурталчилгааны ажил хэрэгжүүлэх санал санаачилга гаргаж буй байдал

#### 4.6.6. Суурь боловсролын дизайн, технологи хичээлээр

##### 4.6.6.А. Суурь боловсролын Дизайн, технологи хичээлээр ТХБ-д оруулах хувь нэмэр

###### Үндэслэл

Орчин цагийн хөгжлийн асуудалд хүний хамгийн эрхэм зорилгын нэг нь тогтвортой хөгжлийн боловсрол, түүнийг практикт хэрэгжүүлэх чадамжтай байх явдал юм.

Монгол улс өнөөгийн хөгжлийн бодлогын нэг үндсэн чиглэлээ аж үйлдвэрийн салбар, жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэхтэй холбоотой технологи, инновацийн асуудлыг бодлогын түвшинд авч үзэх болсон билээ. Иймд инженер (бүх чиглэлийн), архитектор, зохион бүтээгч, тусгай инженерийн анги болох цэргийн, нисэхийн инженер, технологич, дизайнер, багш, зураач, эмч гэх мэт мэргэжлийн боловсрол эзэмшихэд суралцагчийн техник, электроник, хувцасны технологи, дизайн, зураг төслийн мэдлэг эзэмшүүлэх, бие хүний бүтээлч чанарууд, зурах, унших, зохион бүтээх чадварыг хөгжүүлэх, бие даан суралцах сэдэл тэмүүлэл бүхий чадвар, хандлагыг төлөвшүүлэх хэрэгцээ бий болж байна.

Бүрэн дунд боловсролын заавал судлах дизайн, технологийн сургалтын үр дүнд суралцагч дизайн, зураг зүй, техник, технологийн мэдлэгтэй, зохион бүтээх сэтгэлгээ, гүйцэтгэлийн ур чадвартай, тасралтгүй суралцах, хөгжих арга барил эзэмшсэн, бүтээлч хандлага бүхий иргэн болон төлөвших юм.

###### Агуулгын интеграцын тодорхойлогдсон байдал

Суурь боловсролын дизайн технологийн цөм хөтөлбөрт шинжилгээ хийж тогтвортой хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулах өөр хэлбэл ТХ-ийн зорилго ба сэдэвт шууд хамаарах суралцахуйн зорилтыг ялган авахад дараах байдалтай байна.

ТХЗ сэдэвтэй хамаарах суралцахуйн зорилт (тоогоор)

Ай	Танин мэдэхүй	Нийгэмшил, сэтгэл хөдлөл	Зан төлөв
Суралцахуйн зорилтын тоо	3	6	4

Суурь боловсролын хүрээнд нийт 13 суралцахуйн зорилтыг сонгон авснаас ТХ302-Өлсгөлөнгүй тэглэх-1, ТХ303-Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал-1, ТХ304-Чанартай боловсрол-3, ТХ308-Зохистой ажил ба эдийн засгийн өсөлт-2, ТХ309-Үйлдвэрлэл, инноваци, дэд бүтэц-1, ТХ312-Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл-3, ТХ315 -Газар дээрх амьдрал-1, ТХ317-ТХ-ын төлөөх түншлэл-1 гэсэн зорилгуудыг дизайн технологийн агуулгатай интеграцчилах боломжтой байна.

Суралцагчдыг тогтвортой хөгжлийн боловсролтой иргэн болгож төлөвшүүлэхэд дизайн технологийн боловсролын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол асар их юм.

- Суурь боловсролын дизайн технологи хичээлийн агуулга, сэдвүүд нь ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдвүүдтэй шууд хамааруулан ажиллах боломжтой байна. Үүнд:
- Материалын гарал үүсэл, нөөц, үйлдвэрлэл, түүнийг дахин боловсруулах үйл явцын талаар судлах, хэлэлцэх эргэцүүлэх замаар хэмнэлттэй хандах хандлагыг нэмэгдүүлнэ.
- Өөрийн болон өрх гэр, хамт олны хүрэн дэх асуудлаас хэрэгцээг олж харах, түүнийг шийдэх эдийн засгийн шинэ санаа олох, зохион бүтээх ажилтай холбогдох мэдээлэл цуглуулж эд зүйлсийн дизайны элементүүд, хэлбэр хэмжээ, өнгө, чимэглэл, шинжилгээ хийх замаар санаагаа сайжруулах
- Уламжлалт гар урлалын технологитой танилцах суралцах, материал сонгохдоо байгалийн болон нийлмэл материалын гарал үүсэлтэй холбоотой мэдээлэл, мэдлэг ойлголтоо ашиглах, технологийн эерэг сөрөг нөлөөний талаар өөрсдийн санаагаа хуваалцах
- Хэрэглээнээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах. Хэрэгцээг өрнүүлэх замаар хэрэгцээт зүйл бүтээх хандлагыг нэмэгдүүлэх
- Технологи ажилбарын үед гарсан хог хаягдлыг ангилах дахин ашиглах боломжтойг ялгах, ажлын байрны эмх цэгц аюулгүй байдлыг ханган ажиллах
- Уламжлалт болон орчин үеийн технологийг хослуулан бүтээгдэхүүний санаа, шийдэл олох, түүний ажлын болон тойм зураг, илэрхийлэхдээ зурагзүйн дүрэм стандартыг баримтлан зурах, хэсэгчилсэн огтлол, зүсэлтээр зурж үзүүлэх, эсгүүрийн зураг байгуулах материалын шинж, уран сайхны боловсруулалт хийх, оёдлын болон мод, металлын боловсруулах тусгай зориулалтын багаж, тоног төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон материалыг боловсруулах талаар мэдлэг ойлголттой болох

###### Суралцахуйн зорилт, агуулга, арга зүйн интеграцын тодорхойлогдсон байдал

Суурь боловсролын дизайн технологийн цөм хөтөлбөрт Дизайн, технологийн боловсролын сургалтын арга зүй нь суралцагчийн хөгжлийн тухай онол, танин мэдэхүйн хөгжлийн үе шатны онол, эзэмшихүйн (баримжаалах, эзэмших, үнэлэн хөгжүүлэх) зүй тогтол, суралцагч өөрөө мэдлэгээ бүтээж хэрэглэх бүтээлч зарчимд тулгуурласан байдаг. Иймд тогтвортой хөгжлийн зорилго болон дизайн, технологийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ хүүхдийн хэрэгцээ, сонирхол, туршлага, чадварт суурилж, тэдний бүтээлч эрэл хайгуул хийх, бие даан суралцах, бүтээлч сэтгэлгээ, зохион бүтээх авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн арга зүйг сонгох, цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилт, тогтвортой хөгжлийн зорилт ба сэдвийн хамаарал, сурагчдын нас сэтгэхүйн онцлог зэргийг харгалзана.







<p>8.02. 2. Уламжлалт болон орчин үеийн технологийг санаа, шийдэл олох, түүний ажлын болон тойм зураг, илэрхийлэхэд зургагчид дүрэм стандартыг баримтлан зургагчид зурж чухал, эсэргэлтээр зурж чухал, эсэргэлтээр зурж чухал, материалын шинж, уран сайхны боловсруулалт, металлын боловсруулалт, зориулалтын багаж, тоног төхөөрөмжийн амжиллах зарчим, ашиглалт болон мөргөлдөөний мэдлэг ойлголттой болох</p>	<p>8.01. 4. материал багц, хэрэглэгдэхүүний сонгох, бүтээхэдээ байгал орчинд аюулгүй талаарх ойлголтыг авч үзэх, хэрэгжүүлэх хандлагатай болно</p>	<p>6.02. 2. Хүнсний төхөөрөж, гар багжийн төрөл, зориулалт, хэрэглээ төрөл, зориулалт, хэрэглээ талаар мэдлэг ойлголттой болох</p>	<p>8.Боловсруулах технологи</p>	<p>Зургагчийн дүрэм стандартыг баримтлан бөдлын болон мод, металлын багаж, тоног төхөөрөмжийн зарчим, ашиглалт болон материалыг боловсруулах талаар мэдлэг ойлголттой болохыг тулд, шинжлэх ухаан, технологийн шинж, уран сайхны ажллага, мэдлэг, хувалдах сэдвийн хүрээнд тогтвортой хөгжлийн төлөв, орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн туншлагийг дамжин хэрэгжүүлэхэд хувь нэмж оруулахад чаддаг болох. ТХЗ өөр холбогдож байна</p>	<p>Материал багц, хэрэглэгдэхүүнийг сонгох, бүтээхэдээ байгал орчинд аюулгүй талаарх ойлголтыг авч үзэх, хэрэгжүүлэх нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайга холбогдох байдал сэдвийн хүрээнд хүмүүс бид, байгалиас сэлвэлгид бус эерийн аюулд дэвшүүлж чаддаг болох талаар холбогдож байна</p>	<p>Хүнсний төхөөрөж, гар багжийн амжиллагааны талаар мэдлэг ойлголттой болохын тулд, боловсролын эрэлт хэрэгцээний олон янз байдал, тусгай эрэл хэрэгцээг хангахуйц боловсрол амьдралыг сайжруулж, тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд бүх нийтийн боловсрол тогтвортой хөгжлийн байр хэл болох ТХЗ-ий холбогдож байна</p>	<p>Хүнсийг амилгах, цогц чадамж, бусдаас суралцах чадвар, бусдын хэрэглээ шаардлага үзэл бодол, ил хөдөлгөөнийг ойлгох, хүндэтгэх чадвар, бусдыг ойлгох мэдэжлэгтэй хандаг, баяар оролцсонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх чадвар</p>
<p>8.Боловсруулах технологи</p>	<p>8.01. 4. материал багц, хэрэглэгдэхүүний сонгох, бүтээхэдээ байгал орчинд аюулгүй талаарх ойлголтыг авч үзэх, хэрэгжүүлэх хандлагатай болно</p>	<p>6.02. 2. Хүнсний төхөөрөж, гар багжийн төрөл, зориулалт, хэрэглээ төрөл, зориулалт, хэрэглээ талаар мэдлэг ойлголттой болох</p>	<p>8.Боловсруулах технологи</p>	<p>Зургагчийн дүрэм стандартыг баримтлан бөдлын болон мод, металлын багаж, тоног төхөөрөмжийн зарчим, ашиглалт болон материалыг боловсруулах талаар мэдлэг ойлголттой болохыг тулд, шинжлэх ухаан, технологийн шинж, уран сайхны ажллага, мэдлэг, хувалдах сэдвийн хүрээнд тогтвортой хөгжлийн төлөв, орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн туншлагийг дамжин хэрэгжүүлэхэд хувь нэмж оруулахад чаддаг болох. ТХЗ өөр холбогдож байна</p>	<p>Материал багц, хэрэглэгдэхүүнийг сонгох, бүтээхэдээ байгал орчинд аюулгүй талаарх ойлголтыг авч үзэх, хэрэгжүүлэх нэг хэсэг бөгөөд тэдний байгальтайга холбогдох байдал сэдвийн хүрээнд хүмүүс бид, байгалиас сэлвэлгид бус эерийн аюулд дэвшүүлж чаддаг болох талаар холбогдож байна</p>	<p>Хүнсний төхөөрөж, гар багжийн амжиллагааны талаар мэдлэг ойлголттой болохын тулд, боловсролын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, 2-р арга зүйг сонгон боловсруулахтай ялнэ</p>	<p>Хүнсийг амилгах, цогц чадамж, бусдаас суралцах чадвар, бусдын хэрэглээ шаардлага үзэл бодол, ил хөдөлгөөнийг ойлгох, хүндэтгэх чадвар, бусдыг ойлгох мэдэжлэгтэй ханддаг, баяар оролцсонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх чадвар</p>
<p>8.Боловсруулах технологи</p>	<p>8.01. 4. материал багц, хэрэглэгдэхүүний сонгох, бүтээхэдээ байгал орчинд аюулгүй талаарх ойлголтыг авч үзэх, хэрэгжүүлэх хандлагатай болно</p>	<p>6.02. 2. Хүнсний төхөөрөж, гар багжийн төрөл, зориулалт, хэрэглээ төрөл, зориулалт, хэрэглээ талаар мэдлэг ойлголттой болох</p>	<p>8.Боловсруулах технологи</p>	<p>Тогтлоцот сэтгэлгээний цогц чадамж, Аливаа зүйлийн харилцан замаарыг таньж мэдэн, ойлгох чадвар, зарчмын талаарх мэдлэг ойлголттой болохыг тулд, шинжлэх ухаан, технологийн шинж, уран сайхны ажллага, мэдлэг, хувалдах сэдвийн хүрээнд тогтвортой хөгжлийн төлөв, орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн туншлагийг дамжин хэрэгжүүлэхэд хувь нэмж оруулахад чаддаг болох. ТХЗ өөр холбогдож байна</p>	<p>Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж, Тогтсон хэм хэмжээ, дадал, туршлага санаа бодлод асуулах дэвшүүлэх чадвар, ТХ яриа хэрэгцээг өөрийн гэсэн байр сууриааг байж чадвар</p>	<p>Хүнсийг төхөөрөж, гар багжийн амжиллагааны талаар мэдлэг ойлголттой болохын тулд, Судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, 2-р арга зүйг сонгон боловсруулахтай ялнэ</p>	<p>Хүнсийг амилгах, цогц чадамж, бусдаас суралцах чадвар, бусдын хэрэглээ шаардлага үзэл бодол, ил хөдөлгөөнийг ойлгох, хүндэтгэх чадвар, бусдыг ойлгох мэдэжлэгтэй ханддаг, баяар оролцсонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх чадвар</p>



**4.6.4.Б. Нэгж хичээлийн жишээ: 6-р анги**

*Нэгж хичээлийн сэдэв: Хэрэгцээ ба ашиглалт*

*Нэгж хичээлийн зорилго:* Хэрэглээнээс гарсан дахин ашиглах боломжтой материалуудыг боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах, нөөцлөх, хэрэгцээг өрнүүлэх замаар эд зүйл бүтээнэ.

*Хүрэх үр дүн:* Дизайн, зураг зүй, технологийн мэдлэгээ ашиглан хэрэглээнээс гарсан дахин ашиглах боломжтой материалуудыг боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах, нөөцлөх, хэрэгцээг зүйл бүтээх, сэтгэлгээ, гүйцэтгэлийн үр чадвар арга барил эзэмшин, бүтээлч хандлагыг нэмэгдэнэ.

*Нэгж хичээлээр ТХБ-д хувь нэмэр оруулах үндэслэл*

Дахин ашиглах боломжтой материалуудыг боловсруулах сургалтын үр дүнд суралцагч дизайн, зураг зүй, технологийн мэдлэгтэй, зохион бүтээх сэтгэлгээ, гүйцэтгэлийн үр чадвар арга барил эзэмшсэн, бүтээлч хандлагатай болоход анхаарах

Хүүхэд бүр уралдаан тэмцээн, үзэсгэлэнд бүтээлээрээ оролцох, хамтын судалгаа хийх, төслийн болон дадлага ажил хийх зэргээр хамтран ажиллах, өөрийгөө илэрхийлэх, болон оролцооны арга барилд суралцахад анхаарна. Дизайн, технологийн боловсролоор суралцагчдад бүтээлч эрэл хайгуул хийх арга барил эзэмшүүлэхэд онцгой анхаарах ба сонгож эдлэл зохион бүтээхэдээ түүний эрэлт хэрэгцээг тодорхойлох, тухайн эдлэлийн талаар мэдээлэл цуглуулж, судалгаа хийх буюу дизайны шийдэлд анализ хийх, зохион бүтээх аргуудыг ашиглан шинэ загвар зохиох, технологийн зөв горимоор осол аюулгүй ажиллаж урлан бүтээх, бүтээлээ танилцуулах, үзэсгэлэн гаргах, өөрийн дүгнэлт өгөх зэргээр хэрэгжинэ.

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэвт харгалзах байдал (матриц 1-ээс)*

	<p>Дахин ашиглах боломжтой хаягдал материалууд түүний менежмент, (урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглах )</p>
<p>Үйлдвэрлэл ба хэрэглээн дэх тогтвортой практик туршлага хэрэгтэйг бусдад таниулан сурталчилж чаддаг болох</p> <p>Дахин ашиглах боломжтой материалуудыг нөөцлөн ашиглахаар бэлтгэж сурах</p>	<p>Хэрэглээнээс гарсан дахин ашиглах боломжтой материалуудыг сонгон ашиглах, хэрэгцээг эд зүйлс хийх, нөөцлөх, бүтээх. Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт</p>

Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг ТХЗ-ын суралцахуйн зорилт, сэдэвтэй харгалзуулсан үндэслэл

ТХЗ-ын суралцахуйн зорилт	ТХЗ-ын сэдэв	Үндэслэл, тайлбар
4	5	6
ТХЗ12.НСХ1.	ТХЗ12. Сэ07.	Хог хаягдал, түүний менежмент, (урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглах) сэдвийн хүрээнд хэрэглээнээс гарсан, дахин ашиглах боломжтой материалуудыг сонгон ашиглах, хэрэгцээт эд зүйлс хийх үйлдвэрлэл ба хэрэглээн дэх тогтвортой практик туршлага хэрэгтэйг бусдад таниулан сурталчилж чаддаг болох холбоотой байна.

Арга зүйн сонголт:

Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох (компанит ажил)

Хамтын ажиллагаа нь бүлгийн зохион байгуулалт юм. Хамтын ажиллагааг амжилттай хэрэгжихэд бүлгийн бүрэлдэхүүн хэсгүүдэд зохион байгуулалтын загвар бий болгох хэрэгтэй байдаг. Байгалийн ухаан, технологи, урлаг, математикийн судлагдахуун хоорондын уялдаа холбоонд тулгуурлана. Асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, төсөлд суурилсан сургалтын хэлбэрээр ажиллах.

Тогтвортой байдлын цогц чадамж

Хамтран ажиллах цогц чадамж

Бусдаас суралцах цогц чадамж, бусдаас суралцах чадвар, бусдын хэрэгцээ шаардлага, үзэл бодол, үйл хөдлөлийг ойлгож хүндэтгэх чадвар (өөрийгөө бусдын оронд тавьж ойлгох чадвар) бусдыг ойлгож харилцан хамааралтай байж мэдрэмжтэй хандах чадвар (сэтгэл санааны манлайлал) багаараа хамтран аливаа зөрчлийг шийдвэрлэх чадвар, хамтын оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх, зохицуулах чадвар

Нэгж хичээлийн төлөвлөлт

Судлах цаг: 5 цаг - 200 минут

Ээлжит хичээл 1. Зохион бүтээх ажил.

- Хувилбарыг ашиглан, шинэ санаа гаргах

Алхам 1

- Асуудлыг олж харах, дэвшүүлэх
- Мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх чадварт сургах

Алхам 2

- Сэтгэн бодох, бүтээлчээр ажиллах, судалж мэдэх нөөц бүрдүүлэх

Ээлжит хичээл 2

Алхам 1:

- Хэд хэдэн хувилбар санаа гаргаж, тойм болон ажлын зургаар илэрхийлэх

Алхам 2:

- Багууд дотроо хийхээр сонгосон загварын дизайны санаагаа зураг дүрслэлээр илэрхийлэх

Алхам 3:

- Сурагчид төслийн ажлын баримт бичигтээ загварын зураг зэрэг цуглуулсан мэдээллээ нааж, бичиж, тайлбарлана

Алхам 4:

- Зохиомжид дүн шинжилгээ хийх, харилцан ярилцах, мэтгэлцэх /хэлбэр, өнгө, материал, чимэглэл зэрэгт/

Ээлжит хичээл 3. Цаасан урлалаар бүтээл хийх дадлага ажил - 80 минут

Бэлтгэл ажил. Цаасан шуумал хийх хэрэглэгдэхүүн


- Баримлын шавар дэвтрийн цаас. тарган цавуу (ПВА). ариун цэврийн цаас, бийр, гуаш.

Алхам 1. Хийх зүйлийнхээ зургийг гаргаж, төлөвлөгөө зохионо. Хэрэглэгдэх багаж материалаа бэлтгэнэ.



Алхам 2. Баримлын шаврыг зөөллөн, урьдчилж гаргасан зургийн дагуу эх загварыг хийнэ.

**Санамж:** Дэвсгэр хатуу материал дээр багаж хэрэгсэл ашиглан хийнэ. Нүд ам зэрэг хонхор хотгор гадаргууг нэлээн гүн гаргаж өгнө.



Алхам 3. Эхлээд тусгаарлагч болгож, нойтон цаасаар хоёр удаа давхарлан наана.

**Санамж:** Бэлэн болсны дараа энэ хэсгээр хуурч салах ёстой

Алхам 4. Дараа нь цавуудаж, цаасаа нарийн урж, олон үе давхарлан наана. Энэ үед хуруугаараа сайн мэдэрч, дарж өгөхгүй бол хонхор хотгороор суухгүй хөндий болж болно.

**Алхам 5.** Цаасыг аль болох нарийн уртавтар урж наана. Ингэхэд гадаргуу дээр нугаларч үрчийгүй жигд сууж өгдөг.

**Санамж:** Цаасаа наахдаа нэг үе бичсэн цаас нэг, үе шинэ цаас гэх мэтчилэн ээлжилж наах хэрэгтэй. Учир нь ингэж наахгүй бол зарим газар орхигдож, нимгэн болох магадлалтай байдаг.



**Алхам 6.** Цаасаа хатсаны дараа салгаж авна. Энгийн биш гадаргуутай зүйлийг авахад элдэв түгжээ үүсдэг учир зарим газраар зүсэлт хийж авна.

**Алхам 7.** Дараа нь эвлүүлж наана.

**Алхам 8.** Өнгөлөх

Замаск зуурахдаа ус, цавуу, замаскийг тохирох хэмжээгээр хольж найруулна. Цавуу ихэдвэл хатуу гялгар болж, будаг тогтох нь тааруу болно. Цавуу багадвал үйрч унадаг тул найрлагыг сайн тохируулах хэрэгтэй. Зуурмаг шингэвтэр тараг шиг байвал болно.

Төсөлт ажлын үр дүнд эцсийн бүтээгдэхүүн буюу бүтээлийн үзэсгэлэн гаргах.

#### Үнэлгээний шалгуур (Хамтын үнэлгээ)

№	Бүтээлч эрэлхийллийн арга	Үнэлгээний шалгуур	Оноо
1	Асуудал болон хэрэгцээг илрүүлэх	Эд зүйлсийн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж асуудал дэвшүүлэх	10
2	Мэдээлэл цуглуулах дүн шинжилгээ хийх	Хувилбаруудыг цуглуулан хийх арга технологи, бүтэц, материалын талаар судалгаа хийсэн байх	10
3	Дизайны шинэ санаа шийдэл гаргах	Хувилбар гарган шилдэг загварын тойм зураг, ажлын зургийг гаргана	20
4	Бүтээх хөгжүүлэх	Зургийн дагуу уг зүйлээ хийж бүтээнэ.	50
5	Үнэлэх үр дүнгээ танилцуулах	Өөрийн хийсэн бүтээлээ ололттой тал, дутагдалтай тал дээр нь үнэлнэ. Үзэсгэлэнд оролцоно.	10
Нийт оноо			100

#### Ажлын хуудас -1

Чиглүүлэх асуулт	Анхны санаа
Дараах асуултад хариулна уу.	.....
-Хог хаягдал гэж юу вэ?	.....
-Бидний орчинд гарч буй дахин ашиглаж болох хэчнээн төрлийн хог байдаг вэ?	.....
-Хаяхгүйгээр, цэвэрлээд, нөөцөллөө гэхэд хаана нөөцлөх боломж байна вэ?	.....
-Цаасны шинж чанар, боловсруулалтын талаар юу мэдэх вэ?	.....
-Металлын шинж чанар, боловсруулалтын талаар юу мэдэх вэ?	.....
(Хосоороо ажиллах, ойр байгаа 3 баг санаагаа нэгтгэх)	Анхны санаагаа илэрхийлнэ үү.
-Нийт сурагчид нөөц бүрдүүлбэл боломж байна уу? (Хосоороо ажиллах, ойр байгаа 3 баг санаагаа нэгтгэх)	(зургаар эсвэл бичгээр) 15 мин
Хамгийн шилдэг санаа аль нь вэ? Тодруулах хэлэлцүүлэг 10 мин	

#### Ажлын хуудас-2

Юу хийж болох	Үзэг балны сав	Ундааны хуванцар сав	Ундааны бөглөө, гуурс	Бичгийн цаас	Ундааны металл сав
Баримал					
Чимэглэл					
Сав баглаа					
Үзгийн сав					
Тоглоом					
Техникийн загвар					

**Ээлжит хичээл 4.** Хуудсан металлаар хийх дадлага ажил-40 минут

#### Алхам 1

- Хуудсан металлын шинж чанар, нугалах, хайчлах, хэлбэржүүлэхийн тулд хонхойлгох, товойлгох зэрэг өнгөт металлтай ажиллах технологи ажиллагаа өөрийн биеэр хийж үзүүлэх.
- Хөөмлийн аргаар хийж гүйцэтгэсэн жижиг бүтээл дээр аль хэсэгт нь ямар технологи орсон талаар ярилцах

#### Алхам 2

- Хэд хэдэн хувилбар санаа гаргаж, тойм болон ажлын зургаар илэрхийлэх

#### Алхам 3

- Багууд дотроо хийхээр сонгосон загварын дизайны санаагаа зураг дүрслэлээр илэрхийлэх

#### Алхам 4

- Сурагчид төслийн ажлын баримт бичигтээ загварын зураг зэрэг цуглуулсан мэдээллээ нааж бичиж тайлбарлана.

#### Алхам 5

- Зохиомжид дүн шинжилгээ хийх, харилцан ярилцах, мэтгэлцэх /хэлбэр, өнгө, материал, чимэглэл зэрэг/

**Хэрэглэгдэхүүн:**

Дизайн, технологийн хичээл нь тусгай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий зориулалтын кабинетад группээр зохион байгуулагдана.

Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигладаг тул аюулгүй ажиллагааг дээд зэргээр хангах ёстой, тодорхой материалаар эдлэл бүтээгдэхүүн хийх, сурагчдын бие даасан үйл ажиллагаа дээр тулгуурлан явагддаг, багш сурагч нэг бүртэй тулж, зааварчлан ажиллах шаардлагатай зэрэг онцлогтой хичээл тул нэг удаагийн хичээл 80 минутаар орно.

Дизайн, технологийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хэрэглэгдэхүүнүүд зайлшгүй хангагдсан байх шаардлагатай. Үүнд:

- Уламжлалт технологийн гар багаж, хэрэгслүүд
- Зурагт үзүүлэн, бүдүүвч, диаграмм

Хөөх, хайчлах, хэлбэржүүлэх, нугалах технологи ашиглан хийж гүйцэтгэсэн жижиг бүтээл дээр аль хэсэгт нь ямар технологи орсон талаар ярилцах

**Үнэлэх стратеги, арга, хэлбэр:**

- Суралцахуй нь салангид үе шатууд бус тасралтгүй хөгжих процесс учир өмнөх мэдлэг чадварыг тодорхойлох, (суралцагчдын одоогийн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрөх)
- Багш сурагчийн хэн хэнд нь зорилго нь ойлгомжтой зорилгод хүрэх зорилтууд тодорхой
- Зорилтод хүрсэн амжилтын шалгууруудыг (юуг мэдэх ёстой вэ?) тодорхой томъёолж өгсөн байх
- Хүндрэлийн түвшинд (агуулга хүнд, шинэ, танил бус нөхцөлд мэдлэгээ ашиглах чадвар) хүрсэн эсэхэд мониторинг хийх
- Багшийн өгч буй дүн, эргэх холбоо нь дүнгийн хувьд оновчтой тайлбарласан байх
- Үр дүнд хүрэх үзүүлэлтүүд болон амжилтын баталгаа юу байх талаар хичээл эхлэхийн өмнө тодорхой бөгөөд зөв тайлбар өгөх, танилцуулах
- Шалгуурт суурилсан оноо- дүн болон үр дүнд харьяалах үнэлгээг ялгаж ойлгох
- Шалгуурт суурилсан үнэлгээ оноо нь дээд түвшинд эзэмшсэнийг үнэлдэг байх
- Үр дүн буюу ахисан чадварыг тухайн судлагдахуунаас эзэмшсэн цогц чадамжийг үнэлдэг, шалгуурт суурилсан үнэлгээ нь үр дүн, мэдлэг чадварын бүх түвшнийг хамаардаг.

**4.7. СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА****4.7.1. ТХБ-ыг сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах нь**

ТХБ нь соёлын олон төрөл байдлыг хүндэтгэн үзэхийн хамт одоогийн ба ирээдүй үеийнхэн байгаль орчинд ээлтэй, эдийн засагт өгөөжтэй, шударга зүй ёсны нийгмийн төлөө хариуцлагатай үйл хийж, мэдээлэлд үндэслэсэн шийдвэр гаргах талаар суралцагчдыг чадавхжуулахыг зорьдог.<sup>144</sup> ЕБС-ийн бага, дунд, ангид хэрэгжүүлж буй Сургалтыг дэмжих үйл ажиллагаа болон ахлах ангид хэрэгжүүлж буй сургуулийн мэдлийн цаг нь энэхүү зорилгыг үйл хэрэг болгоход чухал хувь нэмэр оруулах боломжтой юм. Тухайлбал: Иргэний боловсролын цаг нь сурагчдын хүн, байгаль, нийгэмтэй зөв харилцах чадварыг хөгжүүлж, хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуунлаг зан чанар, дадлыг хэвшүүлэхэд чиглэгдэж байгаа нь тогтвортой хөгжлийн үзэл санаа, тогтвортой хөгжлийн боловсролын чадвар, чадамжийг дэмжиж байна. Мөн "... иргэн бүрд үр бүтээлтэй амьдрах, зөв шийдвэр гаргах, орон нутаг болон дэлхийн өмнө тулгарч буй сорилт, бэрхшээлийг шийдвэрлэхэд идэвхтэй оролцоход шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг Тогтвортой хөгжлийн боловсролоор олж авч болно"<sup>145</sup> гэсэн Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн стратегийн 62 дахь чиглэлийг хэрэгжүүлэхэд амьдрах чадвар болон хичээллээс гадуурх үйл ажиллагаа, сургуулийн мэдлийн цаг нь чухал үүрэгтэй болно.

"Сургалтыг дэмжих үйл ажиллагаа" (СДҮА) нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө" батлах тухай 2014 оны А/240 дүгээр тушаалаар бага боловсролын түвшинд 29-58 цагаар, 2015 оны А/220 дугаар тушаалаар суурь боловсролын түвшинд 35 цагаар заавал судлахаар тус тус тусгагдсан бөгөөд "Иргэний боловсрол" (ИБ), "Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа" (АЧСҮА), "Хичээллээс гадуурх үйл ажиллагаа" (ХГҮА) гэсэн 3 үндсэн хөтөлбөрөөр хэрэгжиж, хичээлийн цагт<sup>146</sup> тооцогдох юм. Эдгээрээс "Иргэний боловсрол", "Хичээллээс гадуурх үйл ажиллагаа" нь I-IX ангид орох бол "Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа", нь IV-IX ангид орно.

Мөн БСШУС-ын сайдын 2017 оны А/61-р тушаалаар "Сургуулийн мэдлийн цаг" (СМЦ)-ийн хөтөлбөрийг ЕБС-ийн ахлах ангид сургууль зохицуулах цагийн хүрээнд 70 цагаар хэрэгжүүлэхээр заасан.

Сургалтыг дэмжих үйл ажиллагаа болон сургуулийн мэдлийн цагийн хөтөлбөрүүд нь сурагчдыг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, хариуцлагатай шийдвэр гаргаж, хамтран ажиллаж амьдрах чадвартай, үндэсний дэвшилтэт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг дээдлэн хайрладаг, үнэнч шударга, ёс суртахуунлаг иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгддэг.

Энэхүү үйл ажиллагааны цагуудын хөтөлбөр тус бүрийн зорилго, зорилт, хөгжүүлэх чадвар, арга барил нь ТХБ-ын суралцахуйн зорилт, Тогтвортой байдлын цогц чадамжуудтай дийлэнх нь шууд хамааралтай гэж үзэж болохоор байна.

144 Боловсрол 2030-Инчоны тунхаглал УБ.,2015 он хуудас-46

145 Боловсрол 2030-Инчоны тунхаглал УБ.,2015 он хуудас-46

146 Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ.,2014 он. Хуудас -15 Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ.,2015 он. Хуудас -14